



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 06 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2025 оны 06 дугаар сарын 30-ны өдөр, Даваа гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-4
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	5-37

1.Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ/

5-14

2.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

14-37

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны
06 дугаар сарын 30-ны өдөр /Даваа гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Б.Бейсен ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 24 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 54.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 45 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Томилолттой: С.Ганбаатар, Ц.Идэрбат;
Чөлөөтэй: Ж.Бат-Эрдэнэ, Г.Ганбаатар, М.Ганхүлэг, Л.Мөнхбаясгалан, Р.Сэддорж, А.Ундраа;
Эмнэлгийн чөлөөтэй: С.Лүндэг, З.Мэндсайхан.

Нэг.Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Б.Батбаатар, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төрийн сангийн газрын дарга Б.Цогбадрах, мөн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Н.Мөнхсүх, мөн хэлтсийн шинжээч Ч.Цацрал, Б.Цагаанцэцэг, Төлбөр, тооцооны хэлтсийн дарга Н.Саруул, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ц.Уртнасан, Байгалийн нөөцийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Ц.Уранчимэг, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Н.Нямхүү, Ерөнхий нягтлан бодогч Д.Оюун-Эрдэнэ, Усны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч З.Батбаяр, Ойн газрын дарга Б.Оюунсанаа, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга З.Тулга, Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч З.Цэдэнжав, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын ахлах аудитор С.Бат-Эрдэнэ, Г.Мөнхчимэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал байлцав.

Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн талаарх илтгэлийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч З.Цэдэнжав нар танилцуулав.

Илтгэл болон аудитын дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, Б.Бат-Эрдэнэ, Н.Наранбаатар нарын тавьсан асуултад Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ц.Уртнасан, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч З.Цэдэнжав нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ үг хэлэв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 23 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Б.Батбаатар, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, мөн хэлтсийн ахлах мэргэжилтэн Ж.Төгөлдөр, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, мөн хэлтсийн мэргэжилтэн Б.Анар, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, мөн хэлтсийн ахлах шинжээч Д.Отгонжаргал, Н.Уранцэцэг, Б.Дэнсмаа, Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга Б.Амарбаясгалан, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн шинжээч Т.Хонгор, мөн хэлтсийн мэргэжилтэн Р.Хангал, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ц.Уртнасан, Байгалийн нөөцийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Ц.Уранчимэг, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Н.Нямхүү, Ерөнхий нягтлан бодогч Д.Оюун-Эрдэнэ, Усны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч З.Батбаяр, Ойн газрын дарга Б.Оюунсанаа, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга З.Тулга, Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан, Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга А.Нарантуяа, Монгол Улсын Ерөнхий аудитор

С.Магнайсүрэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч З.Цэдэнжав, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын аудитын менежер Э.Энхбаатар, И.Эрдэнэцэцэг, А.Цогбаяр, ахлах аудитор Ж.Бүжинханд, П.Батцэцэг, Б.Ариунжаргал, С.Бат-Эрдэнэ, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, аудитын менежер Ю.Энхтуяа, ахлах аудитор У.Оюунхүү, Татварын Ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн, мөн газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн байлцав.

Төсвийн төслийн талаарх танилцуулгыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, Б.Уянга, Б.Бат-Эрдэнэ, Н.Наранбаатар, У.Отгонбаяр, М.Мандхай нарын тавьсан асуултад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Байгаль орчин, уур амьсгалын сайд өөрчлөлтийн Б.Батбаатар, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ц.Уртнасан, Усны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч З.Батбаяр, Ойн газрын дарга Б.Оюунсанаа, Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга А.Нарантуяа нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл үг хэлэв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 45 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 02 минут үргэлжилж, 24 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 58.3 хувийн ирцтэйгээр 17 цаг 47 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.БЕЙСЕН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 06 дугаар сарын 30-ны өдөр,
Даваа гараг Төрийн ордон “Үндсэн хууль” танхим 15 цаг 45 минут

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Бейсен: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, ирц 54,2 хувьтай бүрдсэн тул БОХХАА-н байнгын хорооны 2025 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Хуралдааны ирцийг танилцуулъя. Очирбатын Амгаланбаатар ирсэн байна. Пүрэвийн Батчимэг ирсэн байна. Цагаанхүүгийн Идэрбат гишүүн ирсэн байна. Нанзадын Наранбаатар гишүүн ирсэн байна. Жигжидийн Чинбүрэн гишүүн ирсэн байна. Тилеуханы Аубакир гишүүн ирсэн байна. Буланы Бейсен гишүүн ирсэн байна. Мэндбаярын Мандхай гишүүн ирсэн байна. Ухнаагийн Отгонбаяр ирсэн байна. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн ирсэн байна. Сонгобайн Замира гишүүн ирсэн байна. Бадрахын Найдалаа гишүүн ирсэн байна. Болдын Уянгаа гишүүн ирсэн байна.

Байнгын хорооны хуралдааны хуралдаанаар хэлэлцэх асуудал танилцуулъя. Хэлэлцэх асуудал.

1. Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон “Монгол Улсын 2024 онд Төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл. Энэ Засгийн газрын 2025 оны 6 дугаар сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн, 2 дахь хэлэлцүүлэг. Санал, дүгнэлт Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ.

2 дахь асуудал. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслүүд. Засгийн газрын 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдөр өргөн мэдүүлсэн, 2 дахь хэлэлцүүлэг. Санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлэх ёстой.

Хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүд байна уу? Байхгүй байна.

Зарим гишүүд Байнгын хорооны хурал давхцаж байгаа учраас дундуур нь нэмэлт асуулт асууя гэж санал мэдүүлсэн байгаа.

Хуралдааны ирцийг танилцуулъя. Ажлын хэсгийг. Жавхлан сайд Эдийн засгийн байнгын хорооны хуралтай байгаа учраас. ХХААХҮ-ийн сайд Энхбаяр. Батбаатар сайд яасан бол. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд.

Үндэсний аудитын газар Магнайсүрэн Монгол Улсын ерөнхий аудитор. Наранчимэг Санхүү-нийцлийн аудитын газрын тэргүүлэх аудитор, Энхболд

Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын тэргүүлэх аудитор, Энхбаатар Санхүү-нийцлийн аудитын газрын аудитын менежер, Эрдэнэцэцэг Санхүү-нийцлийн аудитын газрын аудитын менежер, Цогбаяр Санхүү-нийцлийн аудитын газрын аудитын менежер, Бүжинханд Санхүү-нийцлийн аудитын газрын ахлах аудитор, Батцэцэг Санхүү-нийцлийн аудитын газрын ахлах аудитор, Ариунжаргал Санхүү-нийцлийн аудитын газрын ахлах аудитор, С.Бат-Эрдэнэ Санхүү-нийцлийн аудитын газрын ахлах аудитор, Г.Мөнхчимэг Санхүү-нийцлийн аудитын газрын ахлах аудитор, Ю.Энхтуяа Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын аудитын менежер, У.Оюунхүү Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын ахлах аудитор,

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам. Ц.Уртнасан ТНБД-ын албан үүргийг орлон гүйцэтгэгч, Ц.Уранчимэг Байгалийн нөөцийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга, Г.Энхмөнх Хүрээлэн буй орчны бодлого, хэрэгжилтийн газрын дарга, Н.Нямхүү Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Д.Оюун-Эрдэнэ Ерөнхий нягтлан бодогч, З.Батбаяр Усны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Б.Оюунсанаа Ойн газрын дарга,

ХХААХҮЯ. Т.Жамбалцэрэн ТНБД, З.Тулга Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Ц.Амгалан Санхүү, хөрөнгө оруулалтын газрын ерөнхий санхүүч, А.Нарантуяа Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга, Я.Эрдэнэсайхан ЖДҮ-ийн газрын дарга, Б.Цогтсаран ХАА-н корпорац төрийн өмчит ХК-ийн захирал, З.Цогтсайхан Зээлийн батлан даалтын сангийн захирал,

Сангийн яамнаас Ж.Ганбат ТНБД, М.Санжаадорж Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Б.Тэлмүүн Татварын бодлогын газрын дарга, С.Тулга Санхүүгийн бодлогын газрын дарга, Ж.Дэлгэржаргал Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, З.Энхболд Хууль, эрх зүйн газрын дарга, П.Бат-Эрдэнэ Төсвийн зарлагын хэлтсийн дарга, Л.Ичинноров Төсвийн орлогын хэлтсийн дарга, Б.Ганзориг Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Л.Гантогтох, Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Б.Амарбаясгалан Санхүүгийн зээл даатгалын хэлтсийн дарга, Э.Номин-Эрдэнэ Төсвийн зарлагын хэлтсийн шинжээч, Б.Дэнсмаа Төсвийн зарлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн, Т.Хонгор Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн шинжээч, Ж.Төгөлдөр Төсвийн орлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн, С.Гэлэгжунай Төсвийн нэгтгэлийн хэлтсийн мэргэжилтэн, Р.Хангал Төсвийн хөрөнгө оруулалтын газрын дарга.

Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгдсэн тайлангийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулах ёстой. Эдийн засгийн байнгын хорооны хурал давхцаж байгаа учраас ХХААХҮ-ийн сайд Жадамбын Энхбаяр танилцуулна.

Ж.Энхбаяр: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгдсэн тайланг хуулийн хугацаанд нэгтгэн гаргаж, Төрийн аудитын төв байгууллагаар аудит хийлгэн, Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын чуулганы 6 дугаар сарын 23-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэгт танилцуулсан билээ.

Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайланд тус Байнгын хороонд харьяалагдах Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, ХХААХҮ-ийн сайд нийт 158 байгууллага, 5 төсөл сан, төрийн

өмчийн 9 ААН, нийт 144 байгууллагын төсвийн гүйцэтгэл санхүүгийн тайланг нэгтгэн гаргасан болно.

Тус Байнгын хорооны төсвийн ерөнхийлөн захирагчдын нийт зарлага болон цэвэр зээлийн дүн 909,9 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй гарч, үүнээс урсгал зардалд 737,2 тэрбум төгрөг, хөрөнгийн зардалд 123,6 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд тус Байнгын хороонд харьяалагдах 2 төсвийн ерөнхийлөн захирагчдын 156 төсөл, арга хэмжээнд 265,2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгож, гүйцэтгэл 81,6 хувийн биелэлттэй байна.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, та бүхэн 2024 оны төсвийн гүйцэтгэлийн үр дүнгийн тоон үзүүлэлтүүд болон бусад холбогдох тайлан танилцуулга, аудитын дүгнэлтүүдтэй танилцаж, Төсвийн тухай хуулийн дагуу “Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж өгнө үү. Анхаарал тавьсанд баярлалаа.

Жавхлант сайдад баярлалаа. Энхбаяр сайдад.

Монгол Улсын 2024 онд нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 онд санхүүгийн нэгдсэн тайланд хийсэн аудитын тайланг Монгол Улсын Ерөнхий аудитор Сандагийн Магнайсүрэн танилцуулах ёстой боловч Эдийн засгийн байнгын хорооны давхцаж байгаа учраас Монгол Улсын ерөнхий аудиторын орлогч Цэдэнжав танилцуулна. 5 номер.

3.Цэдэнжав: Улсын Их Хурлын БОХХАА-н байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Төрийн аудитын тухай хууль болон Төсвийн тухай хуульд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагчдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгдсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тус Байнгын хороонд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгдсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитыг тоймлон танилцуулъя.

1.Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 2024 оны санхүүгийн нэгдсэн тайланд нийт 98 тайлан нэгтгэгдсэнээс 56 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 42 байгууллагыг түүвэрт хамрууллаа.

Аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгдсэн тайланд хязгаарлалттай, харьяа 44 байгууллагад өөрчлөлттэй, өөрчлөлтгүй, 11 байгууллагад хязгаарлалттай, 1 байгууллагын санхүүгийн тайланд татгалзсан дүгнэлт өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 11,4 тэрбум төгрөгийн зөрчил илэрснээс 0,2 тэрбум төгрөгийн 9 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 10,4 тэрбум төгрөгийн зөрчлийг таслан зогсоох, 44 албан шаардлага хүргүүлэв. 0,8 тэрбум зөрчлийг дахин давтан гаргахгүй байх, 36 зөвлөмж өгч, хариуцлага тооцуулах 4 албан шаардлага хүргүүлсэн ба нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 6,9 тэрбум төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 12,6 сая төгрөгийн алдааг арилгах нэг зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудлаар нийт 10,2 тэрбум төгрөг илэрснээс 8,1 тэрбум төгрөгийн зөрчлийг таслан зогсоох, 16 албан шаардлага 2,1 тэрбум төгрөгийн зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 18 зөвлөмж өгч, зөрчил гаргасан 2 албан тушаалтанд хариуцлага тооцуулах тухай 1 албан шаардлага хүргүүлээд байна.

Өмнөх аудитаар урьдчилж гарсан зардлын дансанд 2012 оноос 2022 оны хооронд хуримтлуулан бүртгэсэн ажлуудын тооцоог хянаж баталгаажуулан үлдэгдлийг бууруулах арга хэмжээ авах тухай өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 35,5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 15 төсөл, арга хэмжээг тайлант онд шинээр хэрэгжүүлэхээр баталсан ба төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг хянаж 69,1, хувийн санхүүжилтийг олгосон байна.

2.ХХААХҮ-ийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгдсэн тайланд 64 тайланг нэгтгэснээс 52 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 12 байгууллагыг түүвэрт хамрууллаа.

Аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгдсэн тайланд хязгаарлалттай харьяа 38 байгууллагад өөрчлөлтгүй, 12 байгууллагад хязгаарлалттай, 2 байгууллагад сөрөг дүгнэлт өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 253,1 тэрбум төгрөгийн зөрчил илэрснээс 0,2 тэрбум төгрөгийн зөрчилд 38 төлбөрийн акт тогтоож, 230,8 тэрбум төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 92 албан шаардлага, 22,2 тэрбум төгрөгийн зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 98 зөвлөмж өгч, хариуцлага тооцуулахаар 1 албан шаардлага хүргүүлсэн ба нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 147,6 тэрбум төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 14,2 сая төгрөгийн алдааг арилгах 4 зөвлөмж өгсөн байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудлаар нийт 10,1 тэрбум төгрөгийн зөрчил илэрснээс 1,5 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 6 тэрбум төгрөгийн зөрчлийг таслан зогсох 17 албан шаардлага хүргүүлж, 4,1 тэрбум төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 31 зөвлөмж өгч, хариуцлага тооцуулахаар 1 албан шаардлага хүргүүлээд байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн өмнөх оны санхүүгийн нэгдсэн тайланд хийсэн аудитаар харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд бүртгээгүй 4,5 тэрбум төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй санхүүгийн тайлан, бүртгэл, зөрчлийг арилгах талаар зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 231,1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй тайлан тоонд 120,5 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй шилжин хэрэгжих 80 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна. Үүнээс 49,3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 38 барилга байгууламж ашиглалтад хүлээж авч, тоног төхөөрөмжийг нийлүүлсэн байна. Нийт төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг хянаж 73,7, хувийн санхүүжилтийг олгосон.

Дээр дурдсан аудитын дүн дүгнэлтээс үндэслэн дараах асуудалд анхаарал хандуулах шаардлагатай байна. Үүнд:

1 дүгээрт, төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлсэн хөтөлбөр, хөтөлбөрийн үр дүн, чанар, тоо хэмжээг төсвийн гүйцэтгэлтэй уялдуулан хяналт шинжилгээ үнэлгээ хийж баталгаажуулах,

2.ТӨК-ийн хувьцаа эзэмшигчийн эрхийг үр дүнтэй хэрэгжүүлж, компанийн үндсэн үйл ажиллагаанд хамааралгүй хөтөлбөр, арга хэмжээг компанийн зардлаас санхүүжүүлэхгүй байх,

3.Төсвийн орлогын төлөвлөгөөг өмнөх оны бодит гүйцэтгэлд суурилж үндэслэлтэй төлөвлөн 2026 оны төсвийн саналыг бэлтгэх,

4.Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2026 оны төсвийн төсөл дэх төслийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг холбогдох хууль, журамд нийцүүлэн төлөвлөлтийн шаардлагыг бүрэн нийцүүлж төлөвлөж, саналыг хүргүүлэх,

5.Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд үр дүнтэй хяналтыг хэрэгжүүлж, хуульд заасан хугацаанд хэрэгжилтийг ханган ажиллах,

6.Аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулж, алдаа зөрчил гаргахгүй байхад анхаарах зэрэг болно.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Б.Бейсен: Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгдсэн тайлангийн талаарх Сангийн сайдын танилцуулга болон аудитын тайлантай холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Нэрсээ өгөөрэй.

Бат-Эрдэнэ гишүүнээр тасаллаа Уянга гишүүн асуулт асууя.

Б.Уянга: Өдрийн мэнд хүргэе.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын төсвийн тодотголын дүнг хараад, тэгээд эндээс холбогдох асуултуудаа асууя. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болохоороо 2 агентлагтай, магадгүй олон байж магадгүй. Зүгээр яг ойрхон мэдээллийг нь авч байдаг болохоороо Ойн газар, Усны газар 2 байгаа. Ойн газарт батлагдсан төсөв нь тодотголоор 15 хувийн хасалт орж ирж байгаа юм байна аа. Усны газар нь болохоороо батлагдсан төсвийнхөө 55 хувийг тануулжээ. Тэгээд Усны газраас л мөнгө хасмааргүй байх юм. Нөгөө ой модоо ургуулахын тулд чинь бүгдээрээ ус хэрэгтэй шүү дээ, тийм ээ. Тэгээд эх үүсвэр усаа олохгүйгээр яаж ч ойн газрыг цааш нь ингээд явуулах гээд байдаг юм бол. Тэгээд энэ Усны газартай холбоотой энэ төсөл, хөтөлбөрүүд хамгийн гол нь энэ усны нөөц нуур, гол, мөрний менежментийн хөтөлбөр гээд эднийд нэг хөтөлбөр байгаад байна лээ. Говийн бүсийн газрын доорх усны судалгаа эд нар хийнэ гээд л зөндөө яриад явдаг. Энэ нь л бүгд л хасагдаж байгаа юм шиг л ийм таамаг байна. Тэгээд энэ Байнгын хорооноос орж ирж байгаа дээр Ойн газар болон Усны газрын төсөв нь задаргаагаар орж

ирээгүй учраас бас заавал асуух хэрэгтэй байна. Тэгээд Усны газрын дарга нь байна уу? Тэгвэл Усны газрын дарга энэ усны нөөц нуур, гол, мөрний менежментийн хөтөлбөрийн зардал энэ хасагдаад байгаа 2,9 тэрбумд багтаад байна уу? Танай дээр яг ямар төсвүүд нь үлдэв ээ? Нөгөө яриад байсан газрын доорх усны судалгааг бид нар хийнэ гээд байгаа шүү дээ, тийм ээ. Тэр мөнгө төгрөг нь үлдсэн юм уу, үлдээгүй юм уу. Энэтэй холбоотой мэдээлэл өгөөч.

Энэ Ойн газрын дарга яагаад танайх зөвхөн 15 нөгөө Усны газар, Ойн газар, хоёулаа 38 хүнтэй. Тэгсэн чинь танайх болохоороо 15 хувиар хэд дахин ч их ийм төсөвтэй ч газар юм. Уг нь бүх юмны эх үүсвэр усаа л их анхаараад явчихвал зүгээр байдаг. Тэгээд ямар ч танайхтай холбоотой эсрэг, сөрөг янз бүрийн юм байхгүй шүү. Зүгээр л тоонууд дээр нь ингээд төвлөрөөд харахад ингэж уншигдаад байна аа. Тэгэхээр танай энэ 49 тэрбумаар ямар ажлуудыг хийхээр төлөвлөж байгаа юм бол оо? Яагаад Усны газартайгаа адилхан хэмжээгээр хасагдаагүй юм бол? Энэтэй холбоотой тайлбараа өгчхөөрэй.

Б.Бейсен: Эхлээд Сангийн яам, төрийн нарийн хариулах уу?

Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууя.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Тэгээд энэ гүйцэтгэлтэй холбоотой яах вэ, тэгээд л Үндэсний аудитын газрын хязгаарлалттай дүгнэлттэй холбоотой зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байгаатай холбоотой асуудлууд л байнга л яригдаад л байх юм. Тэгээд энийг яг яах юм бэ? Үндэсний Аудитын газар. Ер нь яах вэ? Яг энэ гүйцэтгэл дээр жишээлбэл би өөрөө БОАЖ-ын сайдаар ажиллаж байсан. Төрийн өмч бодлого зохицуулалтын газартай холбоотой асуудлууд үүсдэг. Нэг талдаа. Жишээлэх юм бол энэ нөгөө харьяалал нь Төрийн өмч бодлого зохицуулалтын газар дээрээ харьяалагдаад байдаг. Гэтэл чиглэл бодлого нь яаман дээр яваад байдаг. Холбогдох албан тушаалтнуудын томилгоо нь ТӨБЗГ-аас хийгдээд байдаг. Чиглэл бодлого нь тухайн яамнаас гараад, хариуцлага тооцох асуудлууд явахаар Төрийн өмч бодлого зохицуулалтын газар дээр очоод хариуцлага тооцогддоггүй байхгүй юу. Би өөрөө энийг өөрөө бодит биеэрээ мэдэрсэн хүний хувьд хэлж байгаа юм. Тэгэхээр Үндэсний Аудитын газар маань яах вэ, зүгээр та бүхэн маань хийх ёстой ч ажил биш байх. Бид нарын л хийх ёстой нэг талын ажил байх.

Цаашдаа энэ гарч байгаа дүгнэлттэй холбоотойгоор ер нь зүгээр нэг иймэрхүү зохицуулалтын хэлбэрээс улбаатай гарч байгаа асуудлуудыг ил тод гаргаад ер нь зүгээр тавьчих шаардлагатай юм болов уу л гэж ойлгоод байгаа юм. Би Байгаль орчин, аялал жуулчлалын сайдаар ажиллаж байхад яг өөрийнхөө харьяаны хүнээ томилдог, бодлого чиглэлээ, төсвөө хуваарилдаг газруудыг албан тушаалтнууд дээр нь ажлаас чөлөөлөх хүртэл арга хэмжээг шууд аваад явчихдаг байсан. Үндэсний аудитын газраас ямар дүгнэлт гарна, ямар зөвлөмж гарна, тэр зөвлөмжийн дагуу бид нар тодорхой арга хэмжээг ажлаас чөлөөлөх хэлбэр дээр шууд явуулж байсан. Тэр нь хаана очиж зогсдог вэ гэхээр ихэвчлэн яамны харьяа нэртэй, тэгэхдээ томилгоо нь ТӨБЗГ дээр явдаг ийм газрууд дээрээс улбаатайгаар яам нь хязгаарлалттай дүгнэлт аваад байдаг байхгүй юу. Яам нь асуудалгүй байдаг. Нөгөө харьяа байгууллагууд нь асуудал гараад байдаг.

Тэгээд нийтээр нь дүгнээд ингээд яаман дээр төсвийн ерөнхийлөн захирагч гэдгээр нь хараад үзэхээр нэг талдаа тэнд асуудлууд яригдаад байдаг. Тэгэхээр энэ дээр та бүхэн маань яг ямар бодолтой байна вэ? Би Байгаль орчин уур амьсгалын

өөрчлөлтийн яамыг өөрөө бас энэ яамыг харьяалаад удирдаад ажиллаж байсан хүний хувьд алдаа дүгнэлт нь тэнд байгаад байдаг учраас ТНБД ч юм уу, тухайн сайдаар ажиллаж байсан хүмүүсийг энэ хүний шууд алдаа юм гэдэг дээр жоохон эсрэг байр суурьтай байгаад байдаг юм. Тэгээд энэ дээр та бүхэн нэг хариулт өгөөч гэж хүсэх гэж байгаа юм. Баярлалаа.

Б.Бейсен: 5 номер Цэдэнжав дарга хариулъя.

3.Цэдэнжав: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Төрийн аудитын байгууллагаас төрийн санхүү, төсвийн хяналтыг хэрэгжүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээг зохион байгуулж явахтай холбоотой энэ 3 төрлийн үндсэн аудитын шийдвэр гарч байгаа. Албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийг өгч ингэж ажиллаж байгаа.

Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу тухайн зөрчлийн байдлаас хамааруулаад зөрчил гаргасан этгээдэд хариуцлага тооцуулахаар эрх бүхий этгээдэд саналыг хүргүүлдэг. Саяын Бат-Эрдэнэ гишүүний асуусан асуулттай холбоотойгоор ер нь Төрийн аудитын байгууллагын энэ шийдвэрийн хэрэгжилтийг бид нар цаашид яаж хэрэгжүүлж ажиллах вэ гэдэг дээр бас нэлээд анхаарч ажиллаж байгаа. Сая Монгол Улсын Ерөнхий аудиторыг шинээр томилогдоход Улсын Их Хурал, Улсын Их Хурлын гишүүдээс бас тодорхой асуулга шаардлагуудыг тавьсан. Төрийн аудитын байгууллага аудитын шийдвэрийн хэрэгжилт, түүний үр нөлөөг дээшлүүлэх чиглэлээр тодорхой бүтцийг байгуулаад ингээд ажиллаж эхлэх гэж байгаа. Тэгэхээр бид энэ асуудалд илүү үр дүн гаргаж ажиллана гэж бодож байна.

Дээрээс нь манай Улсын Их Хурал, Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороод төрийн аудитын байгууллагын гаргасан дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр бас тодорхой тогтоол шийдвэрүүдийг гаргаж өгч, бидний ажилд дэмжлэг үзүүлнэ байх гэдэгт бас итгэлтэй байна аа. Баярлалаа

Б.Бейсен: Бат-Эрдэнэ гишүүн тодруулъя.

Б.Бат-Эрдэнэ: Харин тийм ээ. Тэгэхээр та хэд маань энэ дээр, би бол та нараас юу хүсээд байна гэхээр яг тэр ул суурийг нь л шинэчлэх ажлуудыг хэдүүлээ хамтраад хийхгүй бол болохгүй байхгүй юу. Би танд ганцхан жишээ хэлье. 2015 онд Аялал жуулчлалын хөгжлийн төв нэртэй байгууллагыг татан буулгахаар Байгаль орчны яам, тухайн үеийн БОАЖЯ-нд хандсан. ТӨБЗГ дээр энийг татан буулгаагүй. Төсвийг нь аялал жуулчлалыг дэмжих хүрээнд гэдгээр Аялал жуулчлалын хөгжлийн төвийн төсвийг төсвийн ерөнхийлөн захирагчийн зүгээс Аялал жуулчлалын сайд өгчихдөг байхгүй юу. Тэгтэл тэнд асуудлууд үүсчхээд байдаг. Сая би өөрөө сайд болоод 2022 онд мөн адилхан Аялал жуулчлалын хөгжлийн төвийг татан буулгах асуудлыг хөндсөн. ТӨБЗГ энэ байгууллагыг татан буулгаагүй. Миний мэдэхээр 1,1 билүү 2 тэрбумын асуудал энд дахиад үүсчихсэн явж байгаа. Өмнөх асуудлууд нь ч үүсчихсэн явж байгаа. Нэмэгдсээр байгаад. Тэгээд гэх мэтчилнээс авхуулаад хязгаарлалттайгаас авхуулаад дүгнэлт аваад байна. Энэ дээр хэдүүлээ яах вэ л гэж би асуугаад байгаа юм.

Б.Бейсен: Цэдэнжав дарга хариулъя. 5 номер.

3.Цэдэнжав: Төрийн аудитын байгууллагын гаргасан бас тайлан, зөвлөмж дээр энэ Аялал жуулчлалын үндэсний төвийг татан буулгах тухай асуудлыг бас манайх хөндөж тавьсан байгаа. Ер нь өмнөх жилүүдэд ч бас энэ талаар зөвлөмждөө дурдаад явж байгаа. Их Хуралтайгаа хамтраад Их Хурлын хяналт шалгалтын чиг үүргийг хэрэгжүүлэх чиглэлд дэмжлэг үзүүлэх байгууллагын хувьд төрийн аудитын байгууллагаас энэ төрийн санхүү, төсвийн хариуцлагыг дээшлүүлэх чиглэлд илүү анхаарч ажиллана. Мөн энэ аудитын шийдвэрийн хэрэгжилтийг хангах чиглэлээр бид нар илүү үр дүн гаргаж ажиллана гэж бодож байна. Та бүхнийг дэмжиж ажиллахыг хүсэж байна аа. Баярлалаа.

Б.Бейсен: Наранбаатар гишүүн асуулт асууя.

Н.Наранбаатар: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе ээ. Энэ 24 оны гүйцэтгэлээр ХХААЯ чинь 30 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй ажиллачихсан байх юм. Энэ яагаад ийм их мөнгө хэмнэгдээд үлдэж байдаг юм? Байгаль орчны яам дахиад 30 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй. Тэгээд энэ яагаад нэг ийм их өндөр төсвөө тавиулж аваад тэгээд барж чадахгүй ингээд үлдээд байдаг юм уу, яадаг юм бол. Энэ дээр нэг 2 яам тодруулж өгөөч. Тэгээд, бодвол тодотгол нь эндээсээ эхлээд л хасах байлгүй дээ, 25 онд.

2 дахь нь, энэ хязгаарлалттай дүгнэлт 2 яам хоёулаа авсан байх юм. Энэ ямар зөрчлүүд гарсан юм? Нэг нь 253 тэрбум төгрөг. Үгүй ийм өндөр зөрчил илэрсэн байна шүү дээ. Нэг нь 11 тэрбум төгрөг. Тэгээд Байгаль орчны яам нь 11 тэрбум төгрөг, нөгөө ХХААЯ нь 253 тэрбум төгрөгийн зөрчилтэй ажиллачихсан байх юм. Тэгээд энэ юунаас болж ийм зөрчил гардаг юм. Тэгээд засаж залруулсан юм уу. Ямар хүн хариуцах юм. Зөрчил гарсан бол хариуцах эзэн холбогдогч байх ёстой. Энэ дээр ямар арга хэмжээ авсан юм? Энэ дээр нэг танилцуулаач. Тэгээд энэ жил дахиад зөрчил гаргаад ингээд явж байгаа юу? 25 оны хагас жил болоод явж байна. Энэ арилсан юм уу, үгүй юм уу. Тэгээд урьдахаа арилгаагүй дараагийн төсөв нь ингээд явж байдаг. Тэгээд давхар цаашаа хураагдаад явах юм уу, яах юм гэсэн дээр нэг аудитаас юм уу яамнаас нь мэдээлэл өгөх юм уу гэдэг нэг ийм асуулт байна.

Тэгээд түрүүний тэр яагаад ингээд 30, 40 тэрбумаар нь хэмнээд байдаг юм? Төсвөө худлаа зохиож өгөөд баахан илүү төсөв батлуулж аваад тэрийгээ барж чадахгүй хэмнэлт гараад байдаг юм уу, яадаг юм. Төсөв төлөвлөлт буруу байна уу? Сангийн яам энийг нь үзэж хянадаг юм уу, үгүй юм уу? Тэгээд баахан нөөцтэй ингээд хадгалаад авчихдаг юм уу, яадаг юм. Энэ дээр хариулт аваад, тэгээд тодруулъя.

Б.Бейсен: ХААЯ Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: ХХААЯ дээр хэрэгжиж байгаа урамшуулал болон энэ дэмжлэгийн хөтөлбөрүүдийн гүйцэтгэл ингээд жилийн эцэс рүү шахагдаад, тэгээд хэмнэлтүүд үүсээд байгаа. Жишээлбэл ноосон дээр гэхэд ноосны урамшуулал авах ААН, хоршоод үндэсний үйлдвэрт тушаасан тоо хэмжээ өмнөх үеэсээ багассан. Тэгэнгүүт энэ дээр 10 тэрбум төгрөг ноосон дээр урамшуулал гарахгүй үлдэх жишээтэй. Арьс ширэн дээр бас байгаа. Мөн юун дээр энэ жишээлбэл хүнсний хувьсгал, хоршооны зээлүүд дээр бид нар бүтэн дүнгээр нь тавиад яваад эх үүсвэрээ тавьчихсан байдаг. Ингээд банк дээр зээлүүд гарсаар байгаад, зээл нь бүтэн гараагүйгээр үлдчихээр тэнд зориулсан нөгөө хүүгийн татаас нь дагалдаад үлдчихэж байгаа. Нэг ийм мэтээр хэмнэлтүүд нь энэ манай дээр ирж байгаа 6, 7

хөтөлбөрөөс хэмнэгдсээр байгаад нэг 30-аад тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй ингээд явж байгаа.

Б.Бейсен: Байгаль орчны яам 1 номер. ТНБД урьтаад хариулъя.

Ц.Уртнасан: Наранбаатар гишүүний асуултад хариулъя. 24 оны Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн салбарын сайдын хөрөнгө оруулалтын төсвийн гүйцэтгэл 69,1 хувийн гүйцэтгэлтэй гарсан байгаа. Хөрөнгө оруулалтын энэ төсвийн гүйцэтгэл хангагдаагүй байдал энэ худалдан авах үйл ажиллагааны процесстой холбоотой маргаан үүсэх ч юм уу. Ийм байдлаар гэрээлэн гүйцэтгэх ажил хэрэгжээгүйгээс үүдэлтэй ийм гүйцэтгэл гарсан байгаа. Бусдаар бол хөрөнгө оруулалтын шаардлага хэрэгцээ хэвэндээ байгаа ийм байр байдалтай гүйцэтгэлийн дүн гарсан байгаа.

Б.Бейсен: Цэдэнжав дарга 5 дугаар микрофон, хариулъя. Яагаад хязгаарлалттай санал, дүгнэлт авсан юм, ямар дутагдал гарсан юм.

3.Цэдэнжав: Гишүүний асуултад хариулъя. Байгаль орчин, уур амьсгал, аялал жуулчлалын сайдын санхүүгийн тайланд хязгаарлалттай дүгнэлт өгсөн. Энэ хязгаарлалттай дүгнэлт өгсөн үндэслэл нь Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 9,8 тэрбум төгрөгийн зөрчил илэрсэн. Энэ нь материаллаг байдлын түвшнээс өндөр, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг иж бүрэн байх, нийцсэн байх, зохистой байх зэрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байгаа. Тухайлбал харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар 2,6 тэрбум төгрөгийн залруулагдаагүй зөрчил илэрсэн. Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй, бүрэн хэрэгжээгүй байсан. Цэвэр агаар сангийн эх үүсвэр ... /минут дуусав/

Б.Бейсен: 5 номер нэмж яриулъя.

3.Цэдэнжав: Ийм зөрчлүүд илэрсэнтэй холбоотой хязгаарлагдмал дүгнэлт өгсөн байна.

ХХААХҮ-ийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хийсэн санхүүгийн тайлангаар нийт 253,1 тэрбум төгрөгийн зөрчил илэрсэн. Энэ нь мөн материаллаг байдлын түвшнээс хэтэрсэн тул хязгаарлагдмал дүгнэлтийг өгсөн байгаа. Хариуцлага тооцох тухай албан шаардлага өгсөн байгаа.

Б.Бейсен: Наранбаатар гишүүн тодруулъя гэсэн үү, үгүй юу. Үгүй.

Гишүүд асуулт асууж дууслаа.

Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгдсэн тайлан талаарх Сангийн сайдын танилцуулга болон аудитын тайлантай холбогдуулан үг хэлэх гишүүн байна уу? Нэрсээ өгөөрэй.

Бат-Эрдэнэ гишүүнээр тасаллаа. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн үг хэлье.

Б.Бат-Эрдэнэ: Яах вэ, ингээд нөгөө нүглийн нүдийг гурилаар хуурна гэж үг байдаг. Бид нар энд асуусан болоод тэнд хариулсан болоод, жил болгон

гүйцэтгэлээ хэлэлцсэн болоод, аудитын газар нэг зөвлөмж, дүгнэлт хүргэсэн болоод л жил болгон дуусаж байна. Тэнд хэдэн тэрбумаараа асуудлууд хөндөгдсөн хэвээрээ л байгаа. Үндэсний аудитын газрын буруу биш л дээ. Зөвлөмж хүргүүлэхээс өмнө ямар ч гарц шийдэлгүй. Бид нар эрх зүйн орчин дээрээ тодорхой хэмжээний эрх үүргийнх нь асуудлыг бид нар аль аль талдаа хөндөж өгөхгүй бол болохгүй бол болчхоод байгаа юм. Тэгэхээр бид нар тэрийгээ л хийх ёстой болчхоод байгаа юм. ТӨБЗГ гэж нэг том газар байна. Ний нуугүй хэлэхэд. Би түрүүн бодит жишээ хэлсэн шүү дээ. Аялал жуулчлалын хөгжлийн төв, Үндэсний төв ч гэж явж байсан юм. Татан буулга аа гээд яамных нь сайд бичгээ явуулчихаад байхад татан буулгахгүй. Тэрнээс нь болоод дараа жилүүд дээр тэнд үүссэн асуудлаас улбаатайгаар тухайн яам нь байнгын дүгнэлт дээр хязгаарлалттай юм уу, сөрөг байдаг юм уу дүгнэлт авч байгаа юм. Тэгээд яагаад тэрийг ямар эрх ашгийн үүднээс ТӨБЗГ нь татан буулгадаггүй юм, ерөөсөө тэрийг ойлгодоггүй юм. Аудит оруулдаг.

Одоо би бодит жишээ хэлээд байгаа шүү. Би Аялал жуулчлалын хөгжлийн төв гэдэг газрыг татан буулга гээд бичиг явуулаад, аудит ороод, баахан торгууль болоод зарим нь АТГ-ын асуудал болж хувираад явсан. Тэгээд татан буулгаагүй. Татан буугдаагүй учраас буцаагаад дараагийн сайд нь сэргээгээд ингээд асуудлуудыг нь шийдээд явчих бүрэн боломжтой болчхоод байгаа байхгүй юу. Харьялал нь ТӨБЗГ дээр байгаад байдаг. Төсвийн ерөнхийлөн захирагчаар төсвөө яамнаас аваад байдаг. Төсөв дээр нь Үндэсний аудитын газар дүгнэлт гаргаад байгаа болохоос биш яагаад татан буулгахгүй байгаад, үүнээс улбаатайгаар ийм асуудлууд жил болгон үүсээд байна вэ гэдгийг Үндэсний аудитын газар ерөөсөө олж хардаггүй. Ийм л юмыг яриад байгаа юм.

Тэгээд бид нар энэ суурь шинжтэй ийм тогтолцооны асуудлыг шийдвэрлэхгүйгээр болохгүй шүү дээ. Болохгүй. Би өөрөө дүгнэлт авч байсан. БОАЖ-ын сайдаар ажиллаж байгаад олон улсын төсөл, хөтөлбөрийн хүрээнд ХБНГУ-ын Жи Эс Эйт-ийн шугамаар орж ирсэн 5 машиныг аймгийн байгаль орчинд хуваарилж байсан байхгүй юу. Та улсын төсвийн хөрөнгө оруулалтыг Улсын Их Хурлаар оруулахгүйгээр орон нутгийн өмчлөл рүү шилжүүлсэн байна гээд акт тавьж байсан. Тэр үед нь бас л би энэ асуудлуудыг хөндөж байсан. Тэгээд Үндэсний Аудитын газар маань акт тавих ёстой л газар шиг л бодлогын түвшин дээр ерөөсөө ажил хийхгүй байгаа юм аа. Зөвхөн акт тавьдаг байгууллага шиг ажиллаад байгаа юм.

Монгол Улсын Засгийн газар дээр Эдийн засгийн хөгжлийн яам, Сангийн яам гэж 2 яам байгаа шүү дээ. Эдийн засгийн хөгжлийн төлөвлөлтүүдийг бүгдийг нь Эдийн засгийн хөгжлийн яам дээр хийгээд явж байгаа. Бид нар уул нь Үндэсний Аудитын газрыг ядаж бодлогын түвшин дээр асуудлуудаа гаргаад, яриад, цэгцлээд, хаана юунаас улбаатайгаар үнэхээр энэ аудит дээр хийх процесс дээр хаана ямар алдаа зөрчил дутагдал байна вэ гэдгийг л яриад, хэлээд, засуулахын төлөө бас бодлого шийдвэрүүдээ гаргаад явдаг байгаасай л гэж хүсэж байгаа.

Өнөөдөр та бүхэн яг өнөөдөр энд хариулж байгаа шигээ өнгөрсөн жил яг ингэж хариулж байсан. Уржнан жил бас л яг энийг яриад сууж байсан. Би сүүлийн 30 жилийн хугацаанд та нарыг яг ийм зүйлээ яриад явж байгаа гэдэг дээр бүр бүрэн итгэлтэй байгаа. Хүн нь солигддог, ярьдаг юм нь яг хэвийн. Тэгээд би Үндэсний аудитын газрыг буруушаагаагүй шүү. Та хэд маань зөвөөр ойлгоорой. Тэр үгэнд ордоггүй Төрийн өмчийн бодлого зохицуулалтынхаа газартай асуудлуудыг яаж шийдвэрлэх вэ гэдгээ та нар зарчмын хувьд гаргаж ирэхгүй бол энэ яамнууд,

хөөрхий энэ сайд нар ажил хийх гээд явж байгаа энэ төрийн албаны тодорхой агентлагийн дарга нар та бүхний гаргасан дүгнэлтэд цавчуулсаар л байна. Энэ төрийн албаны албан хаагчдаа бас хамгаалах ёстой зарчмын үг болов уу гэж би бодож байгаа юм.

Б.Бейсен: Энэ сая Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам чинь 11 тэрбум гэсэн үү, 3 гэсэн үү, 18. ХААЯ чинь 240 хэд гэсэн үү, Нараа. Тэгэхээр энэ Ерөнхий аудитор одоо энэ төсвийн ерөнхийлөгч захирагч нарын хариуцлагагүй асуудал уу, аль эсвэл доод талын албан тушаалтнуудын үйл ажиллагаа ажил хийгээгүйн гамшиг байна уу, юу гэж ойлгох вэ?

З.Цэдэнжав: Энэ 2 төсвийн ерөнхийлөн захирагчдын үйл ажиллагаанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил бол холбогдох хууль тогтоомжийн нийцэл түүнтэй холбоотой хариуцлага, ажил хариуцсан ажилтнуудын үйл ажиллагаа болон ер нь бол Монгол Улсын төсвийн тухай хуулиар төсвийн ерөнхийлөн захирагчид өөрийн багцынхаа хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах үүрэгтэй. Ингэж ажиллаж байгаа. Бид энэ үүрэг хариуцлагыг дээшлүүлэх энэ чиглэлээр бас тодорхой ажлуудыг хийж хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа.

Б.Бейсен: Гишүүд үг хэлж дууслаа.

Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон “Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгдсэн тайлангийн 2 дахь хэлэлцүүлгийг хийсэн талаарх БОХХАА-н байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хуралдаанд танилцуулна.

16.23 цаг

Дараагийн асуудалд орёё.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулъя.

Ажлын хэсэг хэвээрээ.

Наранбаатар гишүүн санал гаргах гэж байгаа юм уу, үг хэлэх гэж байгаа юм уу? Наранбаатар гишүүн.

Н.Наранбаатар: Энэ Байнгын хороонд асуудал танилцуулахад заавал энэ яамдын мэргэжилтнүүд ирэх ёстой юм уу. Сайд нь, төрийн нарийн нь байхад л болоо юм биш үү. Тэгээд энэ олон улсуудын ажил алдуулаад энд сууж байснаас явуулж ажилд нь оруулж байвал яасан юм гэсэн санал байна.

Нөгөө 2 нь ажлаа мэдэхгүй бол мэргэжилтнүүд нь сууж байж болно. Ажлаа мэдэж байгаа бол мэргэжилтнүүд нь явж байх хэрэгтэй шүү дээ. Коридороор ч дүүрэн, хөөрхий өдөржингөө зогссон. Энд орж ирээд л ингээд л халуунд бас ингээд сууцгааж байх хэрэг байна уу. Ард нь зөндөө төрийн ажил байгаа байлгүй дээ.

Б.Бейсен: Энэ нөгөө 2024 оны гүйцэтгэл, 2025 оны төсвийн тухай хуулийн өөрчлөлт орж байгаа учраас мэргэжилтнүүдээ дуудсан байх. Яамнуудаас санал авсан байх. Цаашдаа энэ дээр анхаараад бас шаардлагатай мэргэжилтнүүдээ оролцуулахыг бид нар бас дотооддоо хэлэлцээд шийдье, Байнгын хороогоор.

Монгол Улсын 2025 онд Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 онд төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2025 онд Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулах ёстой юм байна. Хуульд өөрчлөлт орж байгаа учраас. Төрийн нарийн танилцуулж байх юм уу? Тийм үү. Төрийн нарийн Жавхаа сайдыг дуудав уу? Юу гэж байна? Энхбаяр сайд, Жавхлан сайд Эдийн засгийн байнгын хороонд юутай учраас та танилцуулна уу.

Ж.Энхбаяр: Баярлалаа. Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Дэлхий дахинд үүсээд буй сорилт, бэрхшээлийн Монгол Улсын эдийн засаг, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, мөн Засгийн газрын бүрэлдэхүүн тухай хуульд өөрчлөлт орсонтой холбоотойгоор Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.2, 34.1.4 дэх заалтын дагуу Монгол Улсын 2025 оны төсвийн тодотголын төслийг боловсруулж, 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн билээ.

Эдийн засгийн сорилт, хүндрэлийг даван туулахад төсвийн сахилга бат, үр ашигтай зарцуулалт онцгой чухал үүрэгтэй. Тиймээс хэмнэлтийн тодотголд бүх шатын төрийн байгууллагуудын тэвчиж болох зардлыг хэмнэх зарчмыг баримтатлаа. Цомхон бүтээмжтэй төртэй байхын тулд төрийн албаны орон тоог 2026 оны хөгжлийн төлөвлөгөөнд нийцүүлэн 9 хувиар бууруулахаар тооцлоо.

Мөн төсвийн байгууллагын тээвэр, шатахуун, дотоод албан томилолт, хичээл, үйлдвэрлэлийн зардал, төрийн өндөр дээд айлчлал болон өндөр түвшний зочин төлөөлөгч авахаас бусад гадаад албан томилолт, зочин төлөөлөгч авах зардал, тавилга, эд хогшил худалдан авах, урсгал засвар хийх болон багаж техникийн зардал, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад олгодог татаасын зардал, байгууллагаас олгох нэг удаагийн болон бусад төрлийн тэтгэмж, урамшуулал, хөтөлбөр, арга хэмжээний зардал зэргийг хэмнэхээр тооцож холбогдох өөрчлөлтийг тодотголын төсөлд тусгалаа.

Энэ хүрээнд байгаль орчны салбарын 2025 оны батлагдсан төсөв нийт 308.6 тэрбум төгрөгөөс 256.4 тэрбум төгрөг болж, хөрөнгийн зардлаас 15.9 тэрбум төгрөг, урсгал зардлаас 36.2 тэрбум төгрөг буюу 52,1 тэрбум төгрөг хасагдсан нь нийт зардлын 17 хувь байна.

Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд туссан төрийн албаны реформын шинэчлэлийн хүрээнд багш, эмчээс бусад төрийн албан хаагчдын орон

тоог 9 хувиар бууруулахаар төлөвлөсний дагуу салбарын хэмжээнд нийт 3202 орон тоо батлагдсанаас 287 орон тоог бууруулахаар төлөвлөсөн.

ХАА-н салбарын 2025 оны батлагдсан нийт төсөв 723 тэрбум төгрөгөөс 676.7 тэрбум төгрөг болж, хөрөнгийн зардлаас 2.3 тэрбум төгрөг, урсгал зардлаас 44 тэрбум төгрөгийг хасагдаж, нийт 46.3 тэрбум төгрөг буюу 7 хувь буурсан байна.

Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд туссан төрийн албаны реформын шинэчлэлийн хүрээнд багш, эмчээс бусад төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулахаар төлөвлөсний дагуу салбарын нийт хэмжээнд 2117 орон тоо батлагдсанаас 187 орон тоог бууруулахаар төлөвлөсөн. Бүх шатын төрийн байгууллагуудын тэвчиж болох зардлыг хэмнэх зарчмын хүрээнд төсвийн зардал 1 их наяд 508,4 тэрбум төгрөгөөр буурна.

Ийнхүү 2025 оны төсөвт тодотгол хийснээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг 3 их наяд 260 тэрбум төгрөгөөр бууруулж, 30 их наяд 209.9 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн нийт зарлагын хэмжээг 1 их наяд 856,5 тэрбум төгрөгөөр бууруулж 31 их наяд 575.1 тэрбум төгрөгт хүргэж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 1 их наяд 365.2 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 1.5 хувийн алдагдалтай болж байна.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон дагалдах хууль тогтоомжийн төслүүдийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Бейсен: Энхбаяр сайдад баярлалаа. Ер нь яамдын сайдуудыг урьсан. Батбаатар сайд яагаад ирэхгүй байна. Энд өнгөрсөн 7 хоногт даргын зөвлөлийн хурлаар энэ Байнгын хорооны хурал батлагдсан шүү дээ. Дуудаарай. Чехийн юун дээр уулзалттай, юу гэсэн үг юм, энэ чинь. Байнгын хорооны хурал тастаад сууж байдаг. Төсвийн гүйцэтгэл, төсвийн хуулийн өөрчлөлтийг хэлэлцэж байдаг. Жавхлан сайдыг дууд. Тэр дуусаж байгаа бол бас дуудаарай, манайхан.

Дараагийн асуудал. Монгол Улсын 2025 онд төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 онд төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 онд төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2025 онд төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд хийсэн аудитын дүгнэлтийн талаар Монгол Улсын Ерөнхий аудитор Сандагийн Магнайсүрэн танилцуулна. 4 номер.

С.Магнайсүрэн: Монгол Улсын Их Хурлын БОХХАА-н байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Төрийн аудитын байгууллага Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Төрийн аудитын тухай хуульд заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 6 сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд дүгнэлт өгөх аудитыг хийж гүйцэтгэлээ.

Засгийн газраас өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тус Байнгын хороонд хамаарах 2 төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нийт 0,3 тэрбум төгрөгөөр, зарлагыг 98,4 тэрбум төгрөг тус тус бууруулахаар төлөвлөсөн байна.

Байнгын хороо төслийг хэлэлцэн шийдвэрлэхдээ дараах асуудалд анхаарал хандуулахыг аудитын энэхүү дүгнэлтээр санал болгож байна.

Төсвийн тодотголоор төрийн албан хаагчдын тоог чиг үүргийн давхардал, ажлын байрны ачаалалд бүрэн шинжилгээ хийлгүйгээр нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан бүх төсвийн ерөнхийлөн захирагч нарын орон тоог жигд 9 хувиар бууруулахаар тооцсон нь төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг бууруулж болзошгүй байна.

Иймд төсвийн ерөнхийлөн захирагчид өөрийн хариуцсан салбартаа чиг үүргийн шинжилгээ, ажлын байрны ба бүтээмжийн үнэлгээ хийсний үндсэн дээр ажлын ачааллыг оновчтой хуваарилах зорилгоор харьяа байгууллагуудын орон тоонд зохицуулалт хийх боломжийг олгох асуудлыг судалж үзэх,

2 дугаарт нь төсвийн тодотголтой хамт Улсын Их Хуралд өргөн барьсан тогтоолын төсөлд 2025, 2026 оны төсвийн жилд өндөр насны тэтгэвэр тогтоолгох болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар чөлөөлөгдсөн орон тоонд нөхөн томилгоо хийхгүй байх, шинээр ажлын чиг үүрэг албан тушаалын орон тоо бий болгохгүй байх, ажлын байрны ачааллыг нягтруулах зэргээр цалин хөлсний зардлыг хэмнэх гэж заасан. Энэ нь чиг үүргийн судалгааг хийсний үндсэн дээр ажлын ачааллыг нягтруулж, орон тоогоо зорилтот түвшин хүртэл нэгэнт бууруулсан байгууллагад сул орон тоонд нөхөн томилгоо хийхгүй байх нь тухайн байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулах, үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл байдал үүсгэх эрсдэл байгааг анхаарах,

3 дугаарт нь төсвийн ерөнхийлөн захирагч нарын харьяа сул орон тооноос бусад цомхотголд орж буй албан хаагчдад төрийн албаны хуулийн 62.1.4-д заасны дагуу ажлаас чөлөөлөгдсөний 3 сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмжийн зардал шаардагдахаар байгааг энэ хуулийн төслийн хэлэлцүүлгийн явцад хамтад нь шийдвэрлэх гарц шийдлийг олох.

Дээрх саналуудаас гадна төсөвт тодотгол хийх нөхцөл үүссэн тохиолдолд төрийн аудитын байгууллагаас аудитын үйл ажиллагааны үе шатын стандартын дагуу хянаж, дүгнэлт гаргахад цаг хугацааны хувьд хязгаарлагдмал байх тохиолдлууд гарч байгааг анхааралдаа авч, дүгнэлт гаргаж, Улсын Их Хуралд хүргүүлэх зохистой хугацааг Төсвийн тухай хуульд тусгаж өгөх шаардлагатай байна.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заасан, хуулийн 23 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан гэж дүгнэснээ үүгээр танилцуулж байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Бейсен: Магнайсүрэн даргад баярлалаа.

Улсын Их Хурлын Тамгын газрын Төсвийн хяналт шинжилгээний хэлтсээс Байнгын хороонд эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн

захирагчдын төсвийн талаарх товч танилцуулгыг бэлтгэн ирүүлсэн. Та бүхэнд хүргүүлсэн байгаа.

Хууль санаачлагч болон аудитын танилцуулга, Байнгын хорооны өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдаас асуулт асуух гишүүд байна уу? Нэрсээ өгөөрэй.

Цагаанхүүгийн Идэрбат гишүүнээр тасаллаа. Идэрбат гишүүн асуулт асууя.

Ц.Идэрбат: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе.

Эдийн засагт үүсээд байгаа нөхцөл байдлыг сайн ойлгож байгаа. Тэгээд төсвийн тодотгол хийхээс өөр аргагүй байдалд хүрлээ гэдэг энэ зүйлийг ойлгож байгаа. Тэгэхдээ энэ удаагийн төсвийн тодотгол бол үндсэндээ хөрөнгө оруулалтаас ажилчид буюу цомхотгол гэж ярьж байгаа. 9 хувь. Урсгал зардал гээд үндсэндээ нэг 3 чиглэлээр нэлээн эрчимтэй явагдах гэж байна. Үүнийг дагаад бас Засгийн газрын тогтоол гарна гэсэн ийм чиглэлтэй байгаа.

Тэгэхээр хөрөнгө оруулалтуудаас энэ салбарын 2 яам БОХХАА-н яамнаас хэчнээн нэр төрлийн хэчнээн төсөл, хөтөлбөр 5 сарын 31-ний өмнө татагдаж байгаа вэ. Нэг.

Татагдсан шалтгаан юу вэ. Шалтгаан нь юу вэ гэсэн 2 асуулт.

Энэ цомхотгол буюу тэр 9 хувь дээр ер нь салбарын яамнуудаас яг хэчнээн хүн цомхотголд орохоор төлөвлөж байгаа вэ, Та бүхэн. Энэ нь яамнаас байгаа юу, орон нутгаасаа байгаа юу. Эсвэл агентлагуудаас байгаа юу гэдэг.

Дараагийн нэг ээлж бол энэ урсгал зардал дээр энэ бусдаар гүйцэтгүүлэх зардлын нэлээдгүй хувь нь энэ ХАА-н салбар, тэр дундаа мал эмнэлгийн үйлчилгээ нэлээн явдаг. Энэ дээр мал эмнэлгийн салбарын бусдаар гүйцэтгүүлэх буюу нөгөө вакцин тариулсны төлбөр явж байгаа юу, үгүй юү? Одоо ингээд хэрвээ эндээс танагдаад дараа нь үүсэх нөхцөл байдлыг та бүхэн ер нь яаж урьдчилж харж байгаа вэ? Хариу арга хэмжээ ер нь яаж авна гэж төлөвлөж байгаа вэ? Яагаад гэвэл энэ малын өвчин гэдэг чинь гэмтэл гардаг, маш өргөн цар хүрээг хамруулдаг, хариу арга хэмжээнээс өндөр зардлыг шаарддаг. Одоо бол хэрвээ танагдаж байгаа бол энэ Тамгын газар, аймаг, сум, ХАА-н газар гээд ингээд энэ зардлууд чинь бүгд танагдаад, танагдаад явчихаар ер нь бид нар малын өвчин хэрвээ гарвал яаж гүйцэтгэх юм. Вакцинаа яаж тариулах юм гэж.

Дараагийнх нь энэ Засгийн газрын тогтоол гарахаар тогтоолын төсөл дээр юу явж байна вэ гэхээр энэ малын өвчний эсрэг тарилгын 50 хувийг нь зардлыг нь малчдаар гаргуулна гэсэн ийм төсөл явж байна лээ. Тэгээд энэ тал дээр яг амьдрал дээр наад зах чинь хэрэгжих үү? Малчид энийг яаж хүлээж авч байгаа вэ? Өчигдөр бид нар зүүн бүс Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сум орсон. Цаашаа Бичигтийн боомт орсон. Эрдэнэцагаан сумын бүх багуудаар явж бид нар, 3 дугаар багаас бусадтай нь бусдаар нь явж малчидтай уулзсан. Энэ тал дээр мал эмнэлгийнхэн нэлээн түгшүүртэй байгаагаа илэрхийлж байна лээ.

Тэгэхээр энэ асуултууд дээр би хариулт авъя гэж ингэж бодож байна.

Б.Бейсен: Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Манай салбарын хэмжээнд 2117 орон тоо батлагдсанаас хэмнэлтээр 187 орон тоо бууруулна. Энэ 187 орон тоог бид нар шаардлагатай бүтцийн өөрчлөлтүүдийг үндсэндээ хийгээд, Засгаараа бүтэц орон тооныхоо лимитээ баталчихсан. Одоо удахгүй сайдын тушаал гараад энэ зохицуулалтууд хийнэ.

Тэгээд салбарт нэлээн, 1 дүгээрт, тэтгэврийн насны улсууд нэлээн байна. Мөн зарим байгууллагууд дээр орон тоо дутмаг явж ирсэн. Ялангуяа аймгуудын ХАА-н газруудад малын эмч, зоотехникч гэх мэтийн мэргэжлийн улсуудын хангалт нэлээн дутуу байсан. Тэгэхээр бид энэ 187 орон тоог нэлээн боломжийн хэмжээнд зохицуулаад нэг айхтар хүндрэл гарахгүйгээр, хүмүүсийг ажлаас халахгүйгээр дотооддоо зохион байгуулах бүрэн бололцоотой. Үндсэндээ энэ 2100 хүн гэдэг чинь нэг жилдээ нэг 10 хувийн эргэлт гараад байгаа шүү дээ. Өөр ажилд шилжинэ, өндөр настны тэтгэвэрт гарна. Тэгээд декретээ авна гэх мэтийн ийм маягаар шилжүүлэхэд бид нар их зөөлөн, харьцангуй зөөлөн, бид нар хийчих бололцоотой. Нэг.

40 гаруй тэрбум төгрөгийн, ер нь нийтдээ нэг 86 тэрбум төгрөгийн хасалт тодотголоор хийгдэж байгаа. Гол зардал бол манай урсгал зардал дээр. Урсгал зардал дотроосоо 10,6 тэрбум орчим энэ мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдээс хасагдаж байгаа. Тэгэхээр мэдээж мал эмнэлгийн үйл ажиллагаа нь нэлээн сөрөг нөлөөллийг үзүүлэх нь тодорхой. Энэ чинь зайлшгүй хийгдэх ёстой энэ малын халдварт өвчин, гоц халдварт өвчин, архаг халдварт өвчин гээд энэ чинь дотроо их олон янз ангилал бас ингээд арга ухаан ч өөр өөр байдаг. Вакцин угаалга туулга нь ч гэсэн өөр өөр байдаг ийм юмнууд байгаа.

Тэгэхээр бидэнд нэгэнт ингээд Засгийн газар шийдээд өргөн барьсан. Бид бусад доторх урсгал зардал дотроо энийгээ хөдөлгөөд, тэгээд аль болох тэгээд хүргээд ямар нэгэн хүндрэл гарахгүйгээр, салбарын өмнө тавьсан хийгдэх ёстой ажлуудаа зохион байгуулаад хийх бололцоотой гэж үзэж байгаа.

Урсгал зал зардал дотроо л жоохон гүйлгэнэ дээ л гэсэн үг. Жишээлбэл юу гэдэг юм, ноосны урамшууллаас жоохон хэмнэгдвэл тэр хэмнэгдсэн мөнгийг мал эмнэлэг рүүгээ өгөөд л, арьс ширэн дээр жоохон юм гарвал тэрийгээ мал эмнэлэг рүүгээ өгөөд л. Ийм хөтөлбөрүүд дээр нөгөө зээлийн хүүгийн татаас зээлд бас заримдаа ингээд наана цаана орж гарахаар жоохон хэмнэлт гардаг. Тэрийгээ мал эмнэлэг рүүгээ өгөөд л ер нь байгаа нөөцийг сайн дайчилна гэсэн үг. Тэгээд 1 дайчлаад хүргэх ёстой.

Б.Бейсен: Батбаатар сайд хариулъя. Батбаатар сайд хэлье.

Б.Батбаатар: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын багцаас 52 тэрбум төгрөг төсвийн тодотголоор хасагдаж байгаа. Хэмнэлтээр 41, 15 гээд нэг 67 тэрбум төгрөг биш ээ, 57 тэрбум төгрөг хасагдаж байгаа. Энэ 52 тэрбум төгрөгөөс хасагдаж байгаагаар одоогийн байдлаар Засгийн газраас тавьж байгаа энэ 9,1 гэдэг тоогоор бодохоор нэг 3202 орон тооноос 287 орон тоо хасагдана гэсэн ийм дүн мэдээ гарч байгаа. Захиргааны албан хаагчдаас хасах чиглэл барина. Сул 70 орон тоо бий. Тэгэхээр энэ нь зөрөө нь яахаар нэг 200 орчим, 217 хүн энэ төсвийн тодотголоор урсгал зардлаас цалингийн зардал нь алга болж хасагдах юм байна.

Б.Бейсен: Батбаатар сайдын микрофон нэмж олгоё.

Б.Батбаатар: Хөрөнгө оруулалтаас 41 тэрбум, КОП-ын 41 тэрбум хасагдсан. Энэ 41 тэрбум төсвийн тодотголоор 41,2 шүү, эргэж орж ирж байгаа. Үүн дээр бид нар нөгөө Төсвийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1.1-ийн заалтыг анхаарах ёстой. Яах вэ гэхлээр нөгөө төсвийн тодотголоор хэмнэлтээр хасагдсан мөнгийг эргүүлж тавихад хэмнэлтийн тухай хуулиар хөрөнгө оруулалт болон худалдан авалтад зарцуулахгүй гэсэн ийм асуудал үүсэж байгаа. Тэгэхдээ энэ асуудлаар Цэц дээр иргэд гомдол юу гаргаад, үүнтэй нь холбогдуулаад Цэц хянаж үзэж байгаа юм байна лээ.

Мөн хөрөнгө оруулалт дээр хэд хэдэн зүйлүүд, нөгөө орон нутгийн байгаль хамгаалагчдын орон байр, харуулын байрууд, дээрээс нь тэр шавж устгал болон ... /минут дуусав/

Б.Бейсен: Гүйцээж хариулъя, Батбаатар сайд.

Б.Батбаатар: Шавж устгал, юу мод тарих энэ асуудлууд хасагдсан.

Дээрээс нь их харамсалтай хасагдаж байгаа төсөв юу вэ гэхлээр радарыг радар тавьсан төсөл, төсөв мөнгө бас хасагдчихсан байж байгаа. Энэ өөрөө юуг хэлж байна вэ гэхлээр сая энэ морин толгой дээр байдаг радар бол аянгад цохигдоод бас тодорхой хэмжээгээр гэмтэл учирсан. Энэ зарим хэсгийг нь хассан, зарим нь засварласан, зарим хэсэг нь засагдаагүй ингээд байж байгаа. Ийм асуудлууд байгаа.

Б.Бейсен: Идэрбат гишүүн тодруулъя.

Ц.Идэрбат: Тийм. Би яах вэ, хөрөнгө оруулалтын энэ зардлууд танагдаад энэ чинь 500, 600-аад тэрбум төгрөг хасагдаж байгаа юм л даа. Тэгээд энэ салбараас нөгөө хэмнэлтийн тухай хуулиар 5 сарын 31-ний өмнө амжаагүй тийм харамсалтай зүйлээс болж байгаа. Тэгээд энийг тавиулах гэж бөөн юм болдог. Тавьсны ар дээр яг тэр салбарт анхан шатанд ажиллаж байгаа хүмүүс чинь нэг энэ нь хийгдчихээсэй гээд ингээд хүлээгээд байдаг. Тэгээд ингээд нэг уялдаа холбоогүй гэдэг юм уу эсвэл яам нь заавал өөрөө зарлана гээд байдаг юм уу дарж хэвтсээр байгаад ингээд 5 сарын 31 болгоод тулгаад зарладаг. Нөгөө тендерийн гомдол нь гарсаар байгаад ингээд, одоо жишээ нь манай Хэнтий аймагт тэр цаг уурын нэг 2 байшин барилга, тэр Биндэрийн 100 жилийн ноднин ч тэмдэглэ лүү. Тэгээд ингээд яамны, би бол яамны урагшгүй үйл ажиллагаа л гэж хэлэх гэж байгаа юм. Зүгээр тэр худалдан авалтыг нь орон нутаг руу нь шилжүүлээд, жоохон байшин барихын төдий тийм ажлыг тэр нэг хурдан явуулчихаж болдоггүй юм уу гэсэн ийм шүүмжлэлтэй л үг хэлье. Өөр тодруулах юм алга. Баярлалаа.

Б.Бейсен: Ганбаяр сайд нэмж хариулах уу? Төрийн нарийн. Төрийн нарийн 3 номер.

Ж.Ганбат: Яах вэ, саяын тэр хэмнэлтийн хуулийн 5 сарын 31-нийг зүгээр дүгнээд үзэх дээр яах вэ, худалдан авах гол удааширч байгаа шалтгаан нь бол ажлын даалгавар техникийн тодорхойлолт удаашрах, удааширч байгаатай холбоотой гол шалтгаан байгаа. Энэ дээр гэрээ байгуулж амжаагүй төслүүд нийт хасагдсан дээрээ 37,1 хувийг нь эзлээд байгаа юм. Тэгээд удаа дараа тендер

амжилтгүй болсон төслүүд 23,8 хувийг нь эзлээд байна. Тэгээд гомдол маргаан гарсан төслүүд 5,8 хувийг эзлээд ийм байдлаар яах вэ, саяын тэр 5 сарын 31 дээр Сангийн яам дүгнэж үзэхэд ийм байдалтай гарч байгаа.

Зүгээр яах вэ, Байгаль орчны яаман дээр улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд санхүүжигдэх дүн нь 80 тэрбум төгрөгөөр батлагдаад нөгөө коп юун дээр коп арга хэмжээ дээр батлагдсан дүнгээс нийтдээ 41 тэрбум төгрөгийг саяын хэлсэн энэ нөгөө худалдан авалт нь, төсөл нь бэлэн болоогүй шалтгаанаар хэмнэгдсэн. Тэгээд нэгэнт яах вэ олон улсад Монгол Улсын Засгийн газар хүлээсэн үүргийнхээ дагуу энийг буцаад ... /минут дуусав/

Б.Бейсен: Ганбат төрийн нарийн гүйцээж хариулъя.

Ж.Ганбат: Яах вэ, энэ дээр ажлын хэсэг дээр Ганхуяг гишүүнээр ахлуулсан том ажлын хэсэг, дэд ажлын хэсгийг нь Бадамсүрэн гишүүн хөрөнгө оруулалтыг нь ахлаад ажиллаж байгаа. Зүгээр яах вэ, ажлын хэсэг дээр бол үүн дээрээс буцааж тавих үндэслэлүүд нь гэдэг дээр бас нэлээн асуудлууд ярьж байна лээ. Тэгээд энэ дээр бид яах вэ, олон улсын нөгөө гэрээ, Монгол Улсын Засгийн газрын хүлээсэн үүргийнх нь дагуу үүнийг буцааж тавихаас өөр арга боломжгүй байсан гэдэг ийм тайлбарууд хэлж байгаа.

Яах вэ, ХААЯ дээр бол гэрээ байгуулагдаагүй 31-ээр 2.2 тэрбум төгрөг хэмнэгдсэн гээд хэмнэлтэд орсон ийм байдалтай байгаа. Түрүүн би нэг Энхбаяр сайдын хэлснээр нэмээд хэлэхэд яах вэ, одоо төсвийн ерөнхийлөн захирагч нар нөгөө тодотгол батлагдсаны дараа төсвийн нөгөө батлагдсан дүн дотроо хийгээд урсгал зардал хоорондоо зохицуулалт хийх эрх нь хуулиараа олгогдчихсон байгаа. Урсгал хөрөнгө оруулалт 2 хоорондоо гүйх нь хуулиар хориотой байдаг. Ийм байгаа. Тэгэхдээ яах вэ, Энхбаяр сайдын хэлдэг урсгал дотроо зохицуулаад ... /минут дуусав/

Б.Бейсен: Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Энэ манай дээр энэ хэмнэгдэж байгаа буюу энэ хуулиар хураагдсан 2,1 тэрбум гэж байгаа юм. Энэ худалдан авах, Төрийн худалдан авах газарт л манайх бүх худалдан авалт нөгөө тендерүүдээ шилжүүлчихдэг. Засгийн шийдвэр гаргаад өгчихсөн. Яам зохион байгуулдаггүй байхгүй юу. Тэгэхээр энд яамны зохион байгуулалтаас боллоо гэдэг юм байдаггүй. Төрийн худалдан авах дээр бие даасан мэргэжлийн агентлаг ажиллаж байдаг. Тэнд манайх бүх эрхүүдээ тийшээ өгчихдөг. Тэд нар нь зохион байгуулаад, тэгээд манайд өгч байгаа тайлбар бол энэ зарласан, танай зарласан тендерт, гүйцэтгэх ийм санал, компаниуд ирсэнгүй гээд. Тэгээд л, тэгээд энэнээс болоод манай ажлууд бас унаж байгаа юм байна. Тэгэхээр энэ дээр бид нар цаашдаа дүгнэлт хиймээр байгаа юм. Тэнд Төрийн худалдан авах ажиллагааны газар зохион байгуулаагүйгээс болоод салбар яамнуудын энэ төсөв хөрөнгө, нөгөө хэрэгжүүлэх ёстой арга хэмжээ нь хойшилж байгаа байдлыг ер нь цаашдаа яах вэ гэж. Тэгэхээрээ тэнд нэг байгууллага асуудал үүсгээд байна гэсэн үг шүү дээ, тийм ээ. Тэгээд тэрийг бас нэг сайн энэ Төсвийн байнгын хороо нь энэ ажлын хэсэгт бүр гаргаад, энийг нэг бас нэг дотор нь ялгаад ... /минут дуусав/

Б.Бейсен: Энхбаяр сайд гүйцээж хариулъя.

Ж.Энхбаяр: Тэр төрийн худалдан авах ажиллагаанаас болсон асуудал нь юу байна. Яамдын өөрсдөөс болсон асуудал юу байна гэж ялгамаар байгаа юм. Энэ нэлээн бүх яаман дээр л адилхан бас ийм зовлон тохиолдож байгаа болов уу гэж.

2 дугаарт, тэр мал эмнэлгийн зардал дээр нь 10-аад тэрбум төгрөгийн вакцины худалдан авалтын асуудлууд хүндэрч байгаа юм. Бүх гэрээ хэлэлцээр хийгдээд батлагдангуут яг сүүлийн хуулийн хугацаанд нь маргаан үүсгэж байгаа юм. Тэгээд маргаантай гэдгээс болоод гагцхаж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ вакцины үйл ажиллагаа бол тасралтгүй, байнга хийгдэх ёстой ажил. Одоо тэтгэвэр, цалин гэдэгтэй адилхан вакцины ажлыг ерөөсөө алдаж болохгүй. Ямар ч байсан заавал явах ёстой гэх мэтийн ингээд нэг бас нэг асуудлууд байна.

Тэгээд энэ маргаанаас болоод энэ вакциныг хасаж байгаа нь бас энэ хуульд нийцүүлээд хасчхаж байгаа нь нөгөө мал мах экспортлох, нөгөө малын эрүүл мэнд, аюулгүй байдал, хүнсний баталгаат байдал гээд олон зүйл маань энэнээс болоод л хүндэрч байна. Бид сүүлийн 2 жил нэг 600 сая долларын мах гаргачхаад байгаа амжилт үзүүлээд байгаа байхгүй юу. Тэгэхээр тэр амжилтын ... /минут дуусав/

Б.Бейсен: Идэрбат гишүүн тодруулъя.

Ц.Идэрбат: Энэ яамдаас ингээд төрийн худалдан авалт руу шилжүүлээд тэнд нь тэгээд 1 ингээд нэг явж өгөхгүй юм ч байгаа. Яам өөрөө анх төсвөө тавиулахдаа тэр зураг төсөв янз янзын юмаа дутуу хөтүү хийсэн юмнууд ч бас байгаа. Янз янзын л юм байгаа. Тэгэхээр яах вэ, миний хувьд бас орон нутаг руу тодорхой үнийн дүнтэйг нь шилжүүлчхаж байвал тэр нэг 2 байшингийн юмыг орон нутагт болгочих л байсан байхгүй юу. Тэгээд дахиж тэрийг тавина гэхэд хэцүү, 1-д.

2-т, би энэ сая Энхбаяр сайдын тэр вакцинтай холбоотой асуудал дээр бол үгүй ээ, энэ бид нар нэг 10 тэрбум төгрөг хэмнээд малын өвчин гарвал тэр байтугай зардал гарах юм шүү. Тэгэхээр энийг ер нь арай өөр журмаар авч үзэх бололцоо байдаг уу, үгүй юү гэж би Сангийн яамнаас асуух гээд байна. Үнэхээр ингээд л өвчин гарлаа гэхэд гар мухар бензингүй нэг хэдэн хүмүүс. Урсгал зардал нь байхгүй, томилолт байхгүй болсон шүү дээ, одоо. Яг ингээд малын өвчин гарахад тэнд яг гардаад ажилладаг муу сумын дарга, тэр нэг малын эмч нар ер нь яг юу гаргаж ажиллах вэ. Вакцин вакцин байхгүй.

Тэгэхээр энэ дээр бас танаж болно. Танах юмаа танаж, авахыгаа авч үлдэж ... /минут дуусав/

Б.Бейсен: Ганбат төрийн нарийн хариулъя, 3 номер.

Ж.Ганбат: Яах нь вэ, Хэмнэлтийн хуулиар яалт ч үгүй ийм хасаж байгаа учраас би хуулийн шаардлагаар давхар дүнг нь оруулж байгаа юм. яах вэ, одоо би сая өмнө нь хэлсний дагуу ХАА-н сайд өөрийнхөө тодотгол баталсны дараа урсгал зардал дотроо зохицуулаад л энийг санхүүжүүлэх ийм л арга байгаа.

Б.Бейсен: Уянга гишүүн асуулт асууя.

Б.Уянга: Батбаатар сайд ороод ирсэн учраас түрүүн би гүйцэтгэл хэлэлцэж байх үеэр асуултаа асуучихсан байсан юм. Тэгээд таны танай яамны харьяанд байдаг Ойн газар, Усны газар гээд хоёулаа тус бүр 38 хүнтэй агентлаг байдаг, тийм

ээ. Тэгээд хоёуланг нь ер нь үйл ажиллагааг нь харж явдаг болохоороо хэчнээн төгрөг таслагдсан юм бол оо гээд тодотголоор зөрөө нь хэр их үүсэж байгаа юм бол оо гээд тооцож үзсэн юм аа. Тэгтэл Ойн газраас болохоороо батлагдсан 25 оны төсвөөс нь 15 хувийн тодотгол орж байгаа юм байна. Усны газраас болохоороо 55 хувь орж байгаа юм байна л даа.

Тэгэхээр усны газрынхаа л энэ төсөл хөтөлбөрүүд дээр санаа зовсон юм. Нөгөө газрын доорх усны судалгаанууд нь явж байгаа хэвээрээ юм уу, үгүй юм уу. Нөгөө усны нөөц нуур, гол, мөрний менежментийн хөтөлбөр гэдэг нь зардал нь ингээд хасагдчихаж байгаа юм уу. Хэрвээ хасагдаж байгаа бол говийн бүсийн тэр газрын доорх усны судалгаа байхгүй болно. Ус хангамжийн нөөцийг тогтоох гээд Дундговь аймгийн бас нэг төсөл байх ёстой. Батбаатар сайд өөрөө мэдэж байгаа байх аа.

Тэгээд би танай 2 агентлагийн дарга нарыг яг энэ холбогдох асуудалд хариулт өгөөч гэж асуусан байгаа.

Б.Бейсен: Батбаатар сайд хариулъя.

Б.Батбаатар: Агентлагийн дарга нараас хариулт авъя гээд хэлчих шиг боллоо. Тэгээд ер нь бол зүгээр энэ, ер нь энэ ойн усны энэ хөрөнгө оруулалт оруулалтуудаас 15 хувь, 55 хувь хасагдаж байгаа. Энэ өөрөө юуг үүсгэж байна вэ гэхлээр одоо тэр Сэлэнгэд гарч байгаа түймрийг харьцангуй гарч байгаа 100 төгрөгийг 20 төгрөгийн зардлаар дарах тэр боломжийг үгүй болгож байгаа шүү дээ. Ойн хувьд ч тэр. Тэр шавж устгалын зардлууд хасагдаж байгаа. Ой бол нэг жил шавжид идэгдээд 2 дахь жилдээ идэгдэхэд тэгээд ойн доройтолд ороод хэдэн мянгаар нь бид нарын тэр 80 хэдэн сая янз бүрийн тоо хэлээд, хүмүүс маргаж л байдаг. Тэр тооны ойг чинь байхгүй болгочхож байгаа шүү дээ. Шавж устгалаа хийхгүйгээр. Ингээд ой усны асуудал хөв цөөрөм, дээрээс нь энэ говийг яаж усжуулах вэ гээд олон олон асуудлууд төсвийн энэ тодотголоор хасагдаж байгаа. Үүн дээр Сангийн яам л төсөв барьж байгаагаараа бараг хариулах нь илүү чухал болоод байгаа юм. Тэгээд Ойн газрын дарга, Усны газрын дарга энэ асуудалд хариулъя.

Дээрээс нь нэг зүйл нэмээд хэлэхэд бид нар нөгөө Эгийн голын УЦС гээд баахан явсан. Орос талдаа маш олон хэлэлцээр, уулзалт, ярилцлага хийсэн. Тэгээд Эгийн голын УЦС-ыг эхлүүлэх тэр боломжийг 2 тэрбум төгрөг энэ Усны газар дээр тавигдаад тэр 2 тэрбум төгрөг алга болчихож байгаа тохиолдолд бид нар эрчим хүч бий болгоно. Эрчим хүчин дээр онц байдал зарлалаа гэж байна. Тэгэхэд Эгийн голын УЦС гэдэг энэ 2 тэрбумыг хассанаар огт байхгүй болно шүү дээ.

Б.Бейсен: 4 номер хариулъя.

Усны газар Батбаяр гишүүний асуултад товч хариулъя. Усны газар дээр 2,2 тэрбум төгрөгийн урсгал зардал буюу цалин хөлсний зардал байж байгаа. 3,2 тэрбум төгрөгөөр гол, мөрний менежментийн хөтөлбөр гээд зардал батлагдсан байж байгаа. Энэ 3,2-ын үлдэгдлийг 2,8 бууруулсан гэж ойлгож байгаа. Энэний Эгийн голтой холбоотой зардал байж байгаа. Сая сайдын хэлсэн 800 орчим сая төгрөгөөр 790 тодруулбал, газрын доорх усны эрэл хайгуулын дунд масштабын зураглал болон Дундговь аймгийн Адаацаг сумд хийх зардал байсан. Өөр нэг 450 орчим сая төгрөгөөр Эрээн нуур, Баяннуур, Говь-Алтай аймгийн Төгрөг сум зэрэг

газруудад хийсэн ажлын үлдэгдэл зардал байж байгаа юм. Хилийн усны хэлэлцээр дээр нэг 230 сая төгрөг гээд. Ингээд өөрөөр хэлбэл гол мөрний хөтөлбөр маань, гол мөрний менежментийн хөтөлбөр маань буурчихаар бид ерөөсөө ажил хийх тун хэцүү болчихож байгаа юм л гэсэн ийм тайлбар хэлмээр байна.

Б.Бейсен: Ойн газрын дарга хариулъя. 4 номер дээр очоод суучих.

Оюунсанаа Уянга гишүүний асуултад хариулъя. Ойн хөнөөлт шавж дээр би голлон ярих гээд байгаа юм. Нийт 16 аймгийн 128 сумын 2,8 сая га талбайд ер нь шавжийн судалгааг хийсэн, тархалтын судалгаа. 436 мянган га талбай юу яачих гээд байна аа. Голомт үүсчхээд байгаа. Энэ жилийн хувьд бид нар 247 мянган га-д нь хийхээр төлөвлөсөн. Нийт төсөвт өртөг болохоор манай хөтөлбөрийн хувьд болохоор 60,9 тэрбум төгрөг, үүнээс 15 тэрбум нь хасагдах гээд байна. 436, 247-гийн хооронд ийм зөрөө гарч байгаа. Тэгээд энэ дээрээ бид нар төслийн ажлыг ингээд хийгээд явж байна.

Түймрийн хувьд та бүхэн бүгдээрээ харж байгаа. Сая ойрын өдрүүдэд юу болж байгааг. Нөхцөл байдал ийм байдаг. Бид нар тарьж ургуулж байгаа гэсэн хэдий ч байгалиа хамгаалах тухай асуудал байдаг. Энэ дээр бид нар төсвөө тавиад арга хэмжээнүүдээ хийгээд явж байгаа. Худалдан авалтын хувьд 70 хувийн гүйцэтгэлтэй явж байгаа. Энд 2 арга хэмжээн дээр.

Б.Бейсен: Уянга гишүүн тодруулъя.

Б.Уянга: Баярлалаа. Батбаатар сайд аа. Би нөгөө энэ асуултыг асуухдаа дотроо ингэж бодсон юм. Ойн газраас нь болохоороо 15 хувь хасаад, Усны газраас нь болохоороо 55 хувиар ингэж хасаж байгаа юмыг чинь жигдэлж болохгүй юм болов уу? Ядаж усныхаа төсвүүдийг аваад үлдчихэж болохгүй юу гэсэн байдлаар асуултаа асуусан боловч яг ингээд сонсохоор байгаль орчны асуудал тэгээд л аягүй хүнд санагдаад. Тэгээд яах вэ, зүгээр яг одоо энэ төсвийн материал дээрээс би юуг харж байна вэ гэхээрээ миний л харснаар шүүх болон прокурор дээр мөнгөнүүд нэмэгдээд ороод ирчихсэн харагдаад байсан. Тэгээд батлан хамгаалах дээр бас нэмэгдчихсэн харагдаад байсан юм аа. Тэгээд тэрэнтэй холбоотойгоор нөгөө гишүүний бүрэн эрхийнхээ хүрээнд зарчмын зөрөөтэй саналыг ажлын хэсэг рүү өгчихье гэж бодож байна. Хамгийн гол нь усан дээр анхаарч байгаа юм аа. Тэгээд та хэд маань дэмжиж ажиллахыг хүсье ээ.

Б.Бейсен: Үг хэллээ. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн асуултаа асууя.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Би нэг юм ойлгохгүй байгаад байгаа юм. Энэ төсвийн тодотголоор ингээд тэгшитгэсэн байдлаар 9 хувь гээд үүрэг өгчихдөг. Нөгөө нийгэм, эдийн засгийн нөлөөллийн үнэлгээ энэ дээр яг хийгдэж байгаа юм уу, хийгдэхгүй байгаа юм уу? Зүгээр л дүнгээ хараад л тоон дээр тулгуурлаад л 9 хувийг нь шууд тана, тэдий хэмжээний төсвийг тана гээд л орж ирээд байх шиг л харагдах юм. Ер нь энэ манай төсөв, төсвийн тодотгол энэ мэргэжлийн байгууллагын суурь шинжилгээ үнэлгээ яг мэргэжлийн байгууллагуудаар хийгдэж явж байгаа юу, үгүй юу. Зүгээр ингээд хараад байхад л Сангийн яам л орж ирж байгаа юм. Сангийн яам тоогоо л яриад байгаа юм. Гэтэл энэ бүтээмжтэй холбоотой асуудал огт хөндөгдөхгүй байгаа.

Одоо сая Уянгаа гишүүн хэлж байна. Энэ Ойн агентлаг, Усны агентлаг 2 чинь 38, 38 хүнтэй шүү дээ. Тэгээд одоо яах юм, 9 хувийг нь хасахаар 3, 3 хүн хасах юм уу. 35, 35 болох юм уу. Тэгээд энэ угаасаа цөөхөн хүнтэй. Дээрээс нь бүгдээрээ өдөр шөнөгүй ажилладаг хүмүүс байгаад байдаг.

2 дугаарт, энэ урьдчилан сэргийлэх ажлуудаас ингэж хамаагүй танаж болохгүй ээ. Малын вакцинаа хасаад байвал эргээд халдварт өвчин чинь ихсээд, өнөөдөр төсвийн тодотголоор танагдсан мөнгө чинь эргээд намар хэд 10 дахин нэмэгдэж орж ирнэ шүү. Монгол Улс МАА-н орон шүү. Энийгээ бид нар маш сайн тооцох ёстой шүү гэдгийг би хэлэх гэж байгаа юм. Урьдчилан сэргийлэх дээр Байгаль орчны яаман дээр гэхэд жишээлбэл тэр ойн хөнөөлт шавжтай тэмцэх асуудлыг сая ярьж байна. Ой хөнөөлт шавжтай тэмцэх ажил хийгдэхгүй байсан учраас миний үед тооцоо судалгаа гаргаж үзэхэд 735 мянган га болсон юм шүү дээ. Ингээд 2022 он, 2023 он, 2024 он тасралтгүй хийж байж, өнөөдөр 430 хэдэн мянган га руу орж ирж байгаа юм. Тэгээд энэ дээр нь 240-өөд мянган га дээр нь ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажил хийгдэх ёстой гээд ингээд мэргэжлийн байгууллага нь оруулж ирэхээр энийг нь танана гээд сууж байж болохгүй ээ. Энэ яагаад ч болохгүй асуудал.

Тэгээд энийгээ бид нар хэзээ ингэж сайн мэддэг болох юм бэ? Батбаатар сайд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдаар томилогдоод бас удаагүй байх шиг байна. Тужийн нарс түймэртэй холбоотой асуудал дээр өчигдөр, уржигдаржингаа л хөөрхий сошиал дээр мэдээллүүд яваад байна. Тэгээд энэ сайд, Байгаль орчны сайд чинь маш их ажилтай, түймэр гээд ингээд яваад өгдөг, ойн хөнөөлт шавж гээд яваад өгдөг, ус гээд яваад өгдөг. Байгаль орчны сайд нар ер нь үе үеийн сайд нар энэ барилга байшинд суудгаа больё оо гээд л уриалга гаргаад л явсан л даа. Тэгээд би Батбаатар сайдыг явж байгаа явдалд дэмжиж байна. Тэгээд энэ байнгын хороодын хуралдаан дээрээ энэ холбогдох албан тушаалтнууд нь байж байвал зарим тохиолдолд бас сайд ажлаа хийгээд явж байсан нь дээр байх. Тэгээд тодруулга хийе, дараа нь.

Б.Бейсен: 3 номер Ганбат төрийн нарийн хариулъя.

Ж.Ганбат: Тэр 9 хувийн хувьд ийм, би тэр юун дээр ЗГХЭГ-ын даргаар ахалсан төрийн хэмнэлт, төрийн бүтээмжийн зөвлөл гээд ингээд ажилласан. Тэгээд үүн дээр нэлээн тийм ажлын байрнууд дээр бас нэлээн дүгнэлт хийгээд, чиг үүргийн давхардал, энэ тэр дээр ажиллаад эндээсээ улбаатай юм гарсан. Нэг дэх нь.

2 дахь нь, сая жилийн хөгжлийн төлөвлөгөө Улсын Их Хурлаар батлагдахад Эдийн засгийн хөгжлийн яаман дээр бас яг энэ чиглэлээр ажиллаад, нийт төрийн албан хаагчдыг 9 хувиар багш, эмч орохгүйгээр 9 хувиар төрийн албан хаагчдын тоог бууруулна гэдэг байдлаар Улсын Их Хурал дээр батлагдчихсан. Эндээс үндэслээд яагаад 10 биш, яагаад 5 биш, 9 гэдэг тоо бол энэ ингээд ажлын хэсгүүд дээр ингэсэн. Сая сүүлд дахиад ЗГХЭГ-ын дэд даргаар ахлуулсан бас ажлын хэсэг ажиллаад, тэр өмнөх төрийн хэмнэл, төрийн бүтээмжийн зөвлөлийн тэр гаргасан судалгаа, тэр ажлын хэсгийн ажил дээр үндэслээд сая энэ 9 гэдэг тоог оруулж ирж, ингэж төсвийн тодотголдоо өргөн барьсан. Багш, эмч нараас бусад салбар дээр 9 хувь.

Засгийн газрын хуралдаан дээр энэ асуудал бас удаа дараа хэд хэдэн удаа яригдсан. Эндээс өгсөн чиглэл бол эхний ээлжид сул орон тоонуудаа орон тооныхоо

хэмжээгээр төрийн албан хаагчдын тоог бууруул гэдэг ийм байдлаар үүргүүд өгөгдсөн. Дараа нь чиг үүргийн давхардал гэдэг ийм байдлаар яг ажлаа хийж байгаа төрийн албан хаагчдыг цомхотголд оруулж, тоог нь бууруулахаас илүү сул орон тоо. Тэгээд ажлын байрны чиг үүргийн давхардал энэ тэр дээрээ үндэслэж энэ тоог бууруул гэдэг ийм үүргийг өгөгдсөн. Тэгээд төсвийн тодотгол баталсны дараа Засгийн газраас бас энэ тал дээр тогтоол гарч бас энэ хэрэгжилт дээр нь ЗГХЭГ голлож ажиллаж, ингэж хяналт тавьж, бас тодорхой чиглэлүүдийг өгч ажиллана гэдэг ийм байгаа.

Нөгөө талдаа 2 дахь нь яах вэ, төсвийн ерөнхий одоо жишээ нь Усны газар, Байгаль орчны яам. Энэ юуны тэр Ойн газар энэ тэр дээрээс хасагдчихлаа. Ингээд урсгал зардал дээр яах вэ. Бид эхний 5 сарын төсвийн гүйцэтгэл хасаад, үлдсэн хугацаанд хэрэгжих дүн дээрээс л хэмнэж олох зардлууд дээр л дүнг нь бууруулсан. Яг л адилхан зарчим барьж байгаад л яах вэ, тооны хувьд бол яг харах дээр өөрөөр харагдаад байгаа юм шиг боловч яг адилхан зарчим бариад хэмнэж болох зардлуудыг үлдэх хугацаанд бууруулаад л явсан. Тэгэх дээр тодотгол батлагдсаны дараа төсвийн ерөнхийлөн захирагч нар урсгал зардлыг дүн дотроо багтаагаад зардлуудаа эрэмбэлээд санхүүжүүлээд явна. Урсгал хөрөнгө оруулалт бол хоорондоо гүйх боломжгүй. Ийм байдлаар энэ төсвийн тодотгол хэрэгжээд явна гэж байгаа.

Б.Бейсен: Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн тодруулъя.

Б.Бат-Эрдэнэ: Харин тэгэхээр харин, Ганбат дарга аа, нөгөө адилхан зарчим л барьж л болохгүй л гэдгийг би хэлээд байгаа юм л даа. Жишээлбэл ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажил 7 сарын 10-ныг, больё жоохон сунахад 7 сарын 20 хүртэл явдаг байхгүй юу. Энэ ойн хөнөөлт шавжтай тэмцэх төсвөөс хасчихвал хугацааных нь хамаарлаар тооцоод хасчихвал энэ чинь барилга байшин барих гэж байгаа ажил биш. Хаашдаа 7 сарын 20 хүртэл явдаг ажил. Энэ чинь шавжныхаа төрлөөс шалтгаалаад цаг хугацааных нь хамаарал гэдэг зүйл энд нөлөөлдөг байхгүй юу. Байгаль орчин дээр. Тэгээд энийгээ бодохгүйгээр ингээд нийтлэг байдлаар нь ингээд хасчихаар чинь болохгүй л гэж гол нь хэлээд байгаа юм л даа.

Батбаатар сайд, тэгээд нөгөө ялд унасан эзэн гэдэг шиг Батбаатар сайд л эцсийн түвшинд л очих юм шиг байна. Энэ урсгал зардал дотроо л асуудлаа шийдэх юм шиг байна. Ойн агентлаг, Усны агентлагийн 38, 38 дотор ямар юмных нь давхардал байх вий дээ чааваас. Давхардлыг нь хасаад 38, 38 болгочихсон байхгүй юу. Тэгээд эндээсээ бага хүн хасаарай.

Б.Бейсен: Хэн хариулах вэ? Батбаатар сайд.

Б.Батбаатар: Миний харж байгаагаар Сангийн сайд зүгээр л юу, хайч барьж байгаад л дээлийн эмжээр хайчилж байгаа юм шиг л хайчилчхаж байгаа шүү дээ. Ойлгож байгаагаар бол. Бат-Эрдэнэ гишүүний хэлдэг тэр эрэмбийн ойлголт байхгүй. Аль салбараас нь танаж болох юм, аль салбар нь болохгүй юм бэ гэдэг тэр эрэмбээ тавьсангүй л гэж би хувьдаа ойлгож байгаа. Тэгээд яах вэ, ингээд нөгөө Засгийн газар дээр ч байна уу, юун дээр ч байна уу ингээд бүгдээрээ нийлээд, ийм ингээд шийдвэр гарчихаар кабинетын зарчмаар гээд зарим зүйлийг хэлэх юм уу, хэлэхгүй юм уу гэдэг нь бас ойлгомжгүй болчихож. Одоо бол энэ төсвийн тодотголууд өөрчлөгдөөд байгаа. Яаж өөрчлөгдөж байна вэ гэхээр олонхын бүлэг дээр

өөрчлөгдөж эхэлж байгаа. Бидэнд тийм боломж алга байна. Тийм учраас Сангийн яамтайгаа ярилцах ёстой. Эрэмбийнхээ асуудлыг дахиж .../минут дуусав/

Б.Бейсен: Бат-Эрдэнэ гишүүн тодруулъя.

Б.Бат-Эрдэнэ: Ойлголоо. Цөлжилт чинь 76,8 хувь оччихсон шүү дээ, найзууд аа. 1976 онд Монгол Улсын цэвдэг 63 хувьтай байсан, 2015 онд 29 хувь болсон. Одоо 2050 онд 16 хувь болох гэж байгаа шүү дээ. Гүний усны хайгуулыг зогсоож болохгүй. Дундговийн тэр юм явах ёстой. Нийт усны судалгаа, тандалт судалгааны бүр 50 тэрбум төгрөгийг Байгаль орчны яаман дээр өнөөдөр нэн шаардлагатай хэрэгцээтэй байгаа. Усгүйгээр амьдрах гээд нэг өдөр үзээрэй. Энд сууж байгаа нэг ч хүн усгүйгээр амьдрахгүй шүү. Тэгээд Байгаль орчны яамнаас ингээд уснаас нь авхуулаад хамгийн хэрэгцээтэй юмнуудыг нь ингээд танаад танаад хаячихсан. Тэгээд сая Батбаатар сайдын ярьж байгаагаар энэ чинь Засгийн газар дээрээ сайн ярилцаагүй л юм байна шүү дээ. Сангийн сайд. Шууд хайчлаад хаячихсан гэж байна шүү дээ. Тэгээд ингэж болохгүй шүү дээ. Ийм байдлаар явбал наад асуудлууд чинь дуусахгүй дээ.

Б.Бейсен: Ганбат төрийн нарийн хариулъя. Үнэхээр хассан юм уу, яасан юм.

Ж.Ганбат: Одоо яах вэ, дахиад хариулъя. Яах вэ дээ, сая би уг нь энэ 9 хувийн цомхотгол энэ тэр дээр бол тэр Засгийн газрын өмнөх ЗГХЭГ-ын даргаар ахлуулчихсан Төрийн бүтээмж, төрийн хэмнэл, төрийн бүтээмжийн зөвлөл дээр 3 талаас оролцож ажилласан ингээд зөвлөл байгаа. Энэ бол хувийн хэвшил, төрийн бус байгууллагууд. Тэгээд Засгийн газар төлөөлөөд энэ 3 дээр нэлээн ярьж байж энэ төр дээр хэмнэж бүтээмжийг нь нэмэгдүүлэх ямар арга хэмжээнүүд байж болох вэ гэдэг дээр ажилласан. Энэ зөвлөл дээр бас нэлээн юмнууд яригдаж байж энэ зардлуудыг бас хэмнэх асуудал санаанууд гарсан. Зүгээр хайч ч бариад хайчлаагүй л дээ. Тэгэх дээр би ялангуяа орон тоон дээр бол ажлын байрны чиг үүргийн давхардал, бүтээмжийн үнэлгээ хийсний үндсэн дээр Эдийн засгийн хөгжлийн яам, ЗГХЭГ ... /минут дуусав/

Б.Бейсен: Төрийн нарийн гүйцээж хариулъя.

Ж.Ганбат: Тэгэх дээр би харин энэ дээр яагаад 9 гэж гаргаж ирсэн гэдгийг тэр ажлын хэсгүүд ажиллаж байж гаргасан. Яагаад 10 биш, яагаад 20 биш, яагаад 5 биш, 9 юм бэ гэдэг дээр багш, эмч орохгүйгээр бусад газар 9 хувийн ингээд төрийн албан хаагчийн тоог бууруулах бололцоотой юм, ийм байдлаар ажилласан л даа. Тэгээд яах вэ, шинээр байгуулагдсан Засгийн газар дээр бас тодотголыг нэлээн хэдэн удаа ярилцаж байгаад, зарчим бариад ийм байдлаар өргөн барья гээд л шийдвэрлэсэн л дээ. Яах вэ, гол яах вэ төсвийн нөхцөл байдал хүндрэлтэй, бас цаашид бас сайжруулах нөхцөл байдал яг одоогийн түвшинд харагдахгүй байгаа учраас яах вэ, ийм хатуу арга хэмжээ авахаас өөр аргагүй нөхцөл байдал үүсээд ингэсэн.

Тэгээд яах вэ, урсгал зардлыг төсвийн ерөнхийлөн захирагч дотор өөрөө зохицуулаад явах, зардлаа эрэмбэлэх байдлаар явах эрх нь нээлттэй үлдэж байгаа учраас төсвийн ерөнхийлөн захирагч нар зардлаа эрэмбэлж санхүүжүүлэхээс өөр арга байхгүй.

Б.Бейсен: Нанзадын Наранбаатар гишүүн асуулт асууя.

Н.Наранбаатар: Ер нь энэ ХАА-н салбар, байгаль орчны салбараас тэгж их цомхотгол хийхэд бас төвөгтэй л дөө. Гол 2 салбар байгаа юм. Тэгээд яах вэ, цалингийн хэмнэлт гээд энэ өмнө нэг яамнаас нь 2 тэрбум, нөгөө яамнаас нь 4 тэрбумын хэмнэлт байна лээ. Тэгээд тэр хэмнэлтийг нь хасаад, тэгээд нэг их хүн хасахгүйгээр явчих боломж байхгүй юу? Ялангуяа энэ аймгуудын ХХААГ-т чинь эрүүл ахуйч, хяналт шалгалт хийдэг хүмүүс их хүрэлцээ муутай байдаг. Хүнсний аюулгүй байдал, хүнсний хангамж гээд яриад байдаг юм. Тэгээд нөгөө хүнсний аюулгүй байдлаа орхичхоод байгаа шүү дээ. Юу идэж ууж байгаагаа ч мэдэхээ байсан. Боловсон хүчингүй болчихсон. Мэргэжлийн хяналтыг нь тараачихсан. Тэгэхээр энэ тал дээрээ төсвийг нь ханахгүй байх, танахгүй байх ийм боломж байдаг юм уу, үгүй юм уу. Нэг мэдээлэл авчихъя. Ийшээ орж байгаа юу, үгүй юу гэдэг дээр.

2-т гэвэл тэр усны төсөл Орхон онги, Цагаан бургастай дээр чинь юм хасагдаж байна уу, үгүй юу. Төлөвлөсөн ажил маань цаашаа явах байгаа. Саяхан бид нар чинь нээлт юмнуудыг нь хийсэн. Энэ дээр тэр хүн хүч, төсөв мөнгөнөөс нь танагдаж байгаа юм байна уу, үгүй юу. Тэрийг нэг тодруулаадахмаар байх юм.

Тэгээд тодруулъя. Эхлээд хариултаа аваадахъя.

Б.Бейсен: 3 номер Ганбатын төрийн нарийн хариулъя.

Ж.Ганбат: Яах вэ, бид нэгэнт Засгийн газар дээр удаа дараа яригдаад өргөн барьчихсан учраас энийг бид буцаах тэр орон зай бид нарт үнэхээр байхгүй. Тийм учраас бид өөрөө байгаа, би байгаа орлогыг бид ямар нэгэн байдлаар өгөхгүй гээд байгаа юм биш. Нөхцөл байдал хүнд байна. Энэнээс цаашаа дахиад хүндрэх бас болзошгүй нөхцөл байдал үүсээд байгаа шүү дээ. Бид нийт орлогыг 3,3 их наядаар бууруулж байгаа. Тэгээд энэнээс цаашаа дахиад экспорт дээр дэлхийн гадаад орчны нөлөөлөл цаашаа хүндэрвэл бид яах вэ гэдэг бас тийм асуудлууд бас асуултын тэмдэгтэй хэвээрээ л байж байгаа шүү дээ, өнөөдрийг хүртэл.

Тийм учраас юу яах гэх дээр 2 дахь нь зүгээр яах вэ, Улсын Их Хурал дээр Хассуурийн Ганхуяг гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг ажиллаж байгаа. Дотроо 2 дэд ажлын хэсэгтэй. Нэг нь хөрөнгө оруулалтын чиглэлээр Бадамсүрэн гишүүн, урсгал зардлын чиглэлээр Ариунзаяа гишүүн ажиллаж байгаа. Түүн дээр ажлын хэсгүүдэд шаардлагатай мэдээллийг нь Засгийн газар болон яамнууд Сангийн яамнаас гаргаж өгөөд л ажиллаж байгаа. Тэнд ямар асуудлууд яригдаж яаж ингэж байгаа гэдэг бол Улсын Их Хурлын бүрэн эрхийн асуудал учраас бид тэндээс тийм юм гэж хэлэхэд боломжгүй байна л даа.

Б.Бейсен: Байгаль орчны яамны төрийн нарийн Уртнасан хариулъя. 1 номерын микрофон.

Ц.Уртнасан: Наранбаатар гишүүний асуултад хариулъя. Засгийн газрын энэ хэмнэлтийн бодлогын хүрээнд орон тоо, урсгал зардлыг тодорхой хэмжээгээр хассан. Энэ дээр бид нар нэгэнтээ Засгийн газрын түвшинд ийм хэмнэлтийн шаардлага байгаа гэдгийг ойлгоод энэ дээр ямар нэгэн тайлбар хэлэх шаардлагагүй байх гэж бодож байна.

Хамгийн гол нь энэ төлөвлөсөн усны хөтөлбөрүүд. Түрүүн Бат-Эрдэнэ гишүүн хэллээ. Сайд хэллээ. Бас энэ байгаль орчны доройтол, уур амьсгалын доройтол

ингээд газар аваад нэлээн өргөн цар хүрээтэй яваад байдаг. Энэ урьдчилан сэргийлэх төлөвлөсөн энэ төсөл, хөтөлбөрүүдийнхээ санхүүжилтийг ингээд танаж байгаа нь нэлээн ажил явуулахад бэрхшээлтэй болж байгаа. Сангийн яаман дээр бид нар бас холбогдох төсвийн газар дээр нь энэ асуудлуудаа нэлээн бүх шатад л ярьсан. Тэгээд тэр нэг ганц харуултай цаг уурынхаа өртөөг хаа гэдэг хүртэл хэмжээнд л иймэрхүү шаардлага тавьсан.

Тийм учраас байдал ийм байгаа юм байна л гэж бид ойлгож аваад л ингээд сууж байна. Ер нь энэ байгаль орчин, уур амьсгалын ... /минут дуусав/

Б.Бейсен: Уртнасан гүйцээж хариулъя. 1 номер.

Ц.Уртнасан: Ойн усны хөтөлбөрүүдийг төлөвлөсөн хөтөлбөрүүдийг зардлыг танаж байгаа нь нэлээн хүндрэл үүсгэхээр байгаа. Говийн устай холбоотойгоор энэ жил энэ говийн усны судалгаа, шинжилгээний нэгжийг бас яамны бүтцэд байгуулаад нэг урсгал зардал дээр нэг 200 орчим сая төгрөгийн зардал байсан. Энэ зардал маань ингээд энэ зардлын юугаар ингээд таналтад орчихсон байдалтай байж байгаа. Цагаан бургастай Онгийн төслийн хувьд бид нар 2026 он дээр төлөвлөж оруулна гэсэн ийм байр байдалтай байгаа.

Б.Бейсен: Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: 230 хүрч байсан нүүрс маань өнөөдөр 70 доллароор тооцогдож орлого бүрдэж байгаа. Тэгэхээр энэ бүсээ чангалаад, гол ачааллыг нь хэмнэлтийг төрийн байгууллагууд тэвчиж болох бүх зардлаа хэмнээд ингээд гаръя гэдэг ийм бодлого улс төрийн шийдэл гарсан. 1 дүгээр асуудал.

2 дугаарт, бид нэгэнт уул уурхайгаас хэт хамааралтай ингэж байсан эдийн засгийг бид нар олон тулгуур тулгахад ХХАА-н салбар их чухал гэдгийг сая 1 дүгээр улирлын мэдээ харуулж байгаа. ХАА-н салбар 35,6 хувийн өсөлтийг 1 дүгээр улиралд үзүүлж, нөгөө бидний нөгөө хэл ам дагуулаад ирсэн олон хөтөлбөр чинь яг үр дүнгээ өгч эхэлж байгаа. Импорт багасаад, экспорт нэмэгдээд, сая ноолуур дээр бид үндсэндээ ноолуураа бүрэн цэвэршүүлж чадлаа шүү дээ. Бүгдийг нь самнаад экспортолдог боллоо. Махан дээр 600 сая долларын экспорт хийдэг боллоо. Газар тариалан дээр томоохон бодлогын өөрчлөлтүүд гараад эхэлж байна.

Нэг минут нэмж авч болох уу?

Б.Бейсен: Энхбаяр сайд гүйцээж хариулъя.

Ж.Энхбаяр: Тэгэхээрээ бид цаашдаа энэ ХХААХҮ-ийн салбараа сэргээж дэмжиж байж энд чинь 600 мянган хүний ажлын байрыг хангаж байгаа. Хөдөө орон нутгийн ер нь тогтвортой хөгжлийн нийгмийн тогтвортой байдлыг хангаж байгаа. Эдийн засгаас гадна улс төрийн их том ач холбогдолтой салбар юм байгаа юм.

Тэгэхээр нэгэнт энэ нүүрсний уналт энэ циклээс бид нар их зөөллөх гол салбар, энэ салбараа бид нар цаашдаа гол хөрөнгө оруулалт, бодлогыг үргэлжлүүлэх, нэмэлт эх үүсвэр тавих, хөнгөлөлттэй зээл олгох, ялангуяа орон нутгийн ХАА-н үйлдвэрлэл, ЖДҮ-үүдийн эрхлэгчдийг энэ зээлийн бодлогоор сайн дэмжиж өгөхгүй бол тэнд бас асуудлууд орхигдоод байгаа байдлууд байгаа. Энэ жилийн бас бид нарын хамгийн том алдаа бол улаан буудайн гурилын

үйлдвэрлэлийн тэр хуультай холбоотойгоор үйлдвэр нэлээн хүчтэй уначихлаа. Тэгээд ийм мэтийн, ийм тогтворгүй ийм жижиг алдаа гаргахгүйгээр ингээд тогтвор ингээд дэмжлэг явахад энэ бол эдийн засагт үзүүлэх нөлөө өсөлт, тогтвортой байдлыг хангахад их маш сайн боломж ирээдүй байна гэдгийг хэлэхийг хүсэж байгаа юм.

Б.Бейсен: Отгонбаяр гишүүн асуулт асууя.

У.Отгонбаяр: Та бүгдэд энэ өдрийн мэндийг хүргэе. Тэгээд төсвийн тодотгол яригдаж байгаа энэ үед бас нэг юмыг асууж тодруулахгүй бас болохгүй нь ээ. Сая өнгөрсөн амралтын өдрөөр зүүн бүсээс сонгогдсон Их Хурлын гишүүд Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сум, Сүхбаатар аймгийн Бичигтийн боомт дээр ажиллаад ирлээ. Ард иргэд, ААН-үүдтэй хэд хэдэн удаагийн уулзалт хийлээ. Тэгээд 1 зүйлийг бүр онцгойлон ХААЯ-аас асууж өгөөч ээ. Та нар одоо өөрсдөө энэ төсвийн тодотгол яриад, төсөв мөнгөтэй холбоотой юм яриад, манайхаас төчнөөн төгрөг хаслаа, хэчнээн төгрөг хаслаа гээд энэ ярьж байгаа үед нь бүр албан ёсоор асууж өгөөч гэсэн юм.

Бичигтийн боомт дээр сая, саяхан би хоног хугацааг нь бас нарийн хэлж мэдэхгүй байна. 20 орчим мянган тонн өвс урагшаа гарах гэж байсан өвс шатаж үгүй болсон байна. 20 орчим мянган тонн өвс гэдэг бол үндсэндээ нэг 4.5-5 тэрбум төгрөгөөр ААН, иргэд хохирсон байна аа. Энэ яагаад хохирсон юм гэхээр өвс гаргахын тулд мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээ, ургамал, хорио цээрийн гэрчилгээ гээд ХААЯ-ны харьяа Мал эмнэлгийн ерөнхий газар, Ургамал хамгааллын газраас зөвшөөрөл гэрчилгээнүүд авдаг. Энэ асуудал сая энэ хавар бүтэн 2 сарын хугацаанд олгогдоогүй байна. Хэрвээ энэ гэрчилгээ цаг тухайдаа олгогдоод, олгогдож чадсан бол тэнд тэр хил дээр өвс тэгж удах шаардлагагүй. Маш хурдан эдийн засгийн эргэлтэд орж урагшаа гарах энэ боломж байсан гэж хохирсон ААН, иргэд бидэнтэй уулзахдаа хэлсэн. Энэ яагаад ингэж гэрчилгээ удав аа? Урьд нь бидний авсан мэдээллээр ГЕГ-аас энэ чөлөө зөвшөөрлөө аваад л маш богино хугацаанд гэрчилгээ юм нь гараад, урагшаа гарчихдаг байсан юм байна. Тэгээд энэ талаар ер нь ХААЯ ямар мэдээ мэдээлэлтэй байгаа вэ? Энэ яагаад гацав. Цаашдаа ер нь яг яах юм? Ингээд ААН, иргэд өөрсдийнхөө энэ хөрөнгөөр, 5 төгрөгөө ингээд салхинд хийсгээд галд шатаагаад ингээд яваад байх уу гэдэг дээр бас та бүгд маань нэг мэдээлэл өгөөч.

Б.Бейсен: Энхбаяр сайд яриулъя.

Ж.Энхбаяр: Зүүн бүсэд өвс бэлтгэгдээд, БНХАУ-д экспортлох асуудал хөндөгдсөн. Би санаж байна. 24 оны 12 сар гэхэд бүх зөвшөөрөл олгогдсон. Монголын тал экспортлохыг урамшуулж, дэмжсэн. Гол асуудал Хятадын хорио цээрийн албанаас тэр өвсийг чинь ариутгах, цэвэрлэх янз янзын нөгөө шаардлагууд нь удлаа гэж надад мэдээ ирсэн. Би маш хурдан арга хэмжээ авсан. Бүгдийг нь гарга. Хилийн бүсэд очсон. Шатах эрсдэл үүсэж байна. Цас бага байна. Нэгэнт зүүн талдаа өнтэй орчхож байгаа ийм цаг үед энэ хадсан өвсийг экспортлох бүх зөвшөөрлийг нь олгосон.

Тэгэхээр тэр ойлголтыг урд талаасаа асуудлууд нэлээн үүссэн шүү. Манай талаасаа биш. Бид аль болох л экспортлох гаргах ийм бодлогыг, ер нь бүх юмыг л гаргах гэж байгаа. Экспорт, үр тариа ч, ургамал, өвс тэжээл, мал мах, хүнс экспортлох бололцоотой болгоныг л бид нар экспортыг дэмжиж байгаа. Тэгж байж

энэ эдийн засгийн тоон үзүүлэлтүүд чинь сайжраад, малчдын орлого тэр аж ахуй эрхэлж байгаа улсуудын орлого чинь яг экспортын үнэ дээр л явж байж л орлого нэмэгдэж байна шүү дээ. Тогтвортой байдлаа хангаад байгаа юм.

Тэгэхээр та тэр ямар ААН юм, надад нэрээр нь өгмөөр байна. Би бол яг гол ААН-ээр нь хэзээ өгсөн бичиг цаасаар нь бүтэн гаргаад би танд өгье. Үнэхээр энэ дотор ганц нэг ААН-ийн юм үлдээд, түүн дээр манай энэ Мал эмнэлгийн ерөнхий газар, Ургамал хамгааллын агентлаг дээр асуудал үүссэн бол хариуцлага тооцоод тэр албан хаагчдыг энэ албанаас зайлуулах хэрэгтэй. Бодлого бол экспортыг дэмжих, ААН-үүдээ дэмжих.

Махан дээр гэхэд бид нар ямар нэгэн квотгүй, хязгаарлалтгүй болгочихсон шүү дээ. Бэлдэж чадсан, гэрээ хийж чадсан болгоныг л экспортоор гаргаж байгаа. Тэгэхээр тэр мэдээллийг та нарийн тэр компанийн тэдэн сарын хүсэлт тэгж ингэж ирээд, тийм дарга дээр удсан байна, гацсан байна гэвэл наад дор нь хөөгөөд хариуцлага тооцоод би мэдэгдэж чадна.

Б.Бейсен: Отгонбаяр гишүүн тодруулъя.

У.Отгонбаяр: Энэ дээр Хятадын талаас гэхээсээ илүүтэйгээр манай Монголын талд гацсан байна. Гэрчилгээ олгогдоогүй байна. 2 сарын 24-нөөс 4 сарын 24-ний хооронд гэрчилгээ олгогдоогүй, систем гацаатай гэрчилгээ хэвлэгдээгүй гэдэг хэд хэдэн шалтгаан Монголын талд байна. Тэрнээс Хятадын талаас тийм шалтгаалах зүйл байхгүй байна. Энэ дээр бас мэргэжлийн хүмүүсээс нь нэмж та бас өөрөө тодруулга аваарай. Мэргэжлийн харьяа агентлагийн дарга нар энд байх шиг байна. Энэ дээр бас мэдээлэл өгөөч ээ.

Б.Бейсен: Нарантуяа дарга Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга. 4 номерын микрофон хариулъя.

А.Нарантуяа: Сайн байцгаана уу? Би сая өгөгдсөн мэдээллээр бас мэдээлэл авлаа. Дэлхийн мал эмнэлгийн эрүүл мэндийн байгууллагын кодексын дагуу бэлчээрийн бэлтгэгдсэн ургамалд Мал эмнэлгийн ерөнхий газар гэрчилгээ олгох асуудал 2 сард шийдэгдсэн. Энэ компанийн хүсэлтийн дагуу нийт 321 гэрчилгээ бичигдсэн байна.

2 сард бол энэ компани өөрөө гадаадад гарах хүсэлтээ өгөөгүй. Яг хариуцсан мэргэжилтэнтэй нь. ГЕГ-аас хариуцсан мэргэжилтэн энэ дээр ажилладаг. Тэгээд мал эмнэлгийн олон улсын гэрчилгээ албан ёсоор шийдэгдэж ирсэн цагаас хойш 600 машин өвс гарах байснаас 200 гаран гараад өөрсдөө гаалийнхаа машиндаа ачиж пүүлүүлж жин тооцоогоо гаргачхаад манайд хүсэлтээ өгсний дараа бичигдэж байсан. Тухайн үед бол энэ гэрчилгээг машин болгоных нь тоогоор Мал эмнэлгийн ерөнхий газраас гаргаж байсан. Тэгээд 4 сарын 21-нээс эхэлж олгож гаргасан гэсэн ийм бичиг байна аа. Тэгээд яг тэр шатах нөхцөл байдал нь тухайн үед бол.

Б.Бейсен: Тодруулах юм уу. Отгонбаяр гишүүн тодруулъя.

У.Отгонбаяр: Зүгээр тэр хаан шатах нь тийм гол асуудал биш байхгүй юу. Цаг хугацааны хувьд хэрвээ тухайн 2 сар гэрчилгээ олгогдоогүй тэр цаг хугацааг бид нар хэмнэсэн бол тэр өвс гараад явчих л ёстой байсан байхгүй юу. Зүгээр тэрийг л яриад байгаа юм. Тэрнээс биш юу гэдэг юм нэг их та нарыг буруутгах гээд байгаа

зүйл биш. Энэ төрийн байгууллагуудын хоорондын энэ шилжилтийн цаг хугацаа чинь өөрөө их урт байгаад байгаа байхгүй юу.

Өнөөдөр ГЕГ-аас танайх руу шилжиж очоод дараагийн гэрчилгээ бичигдээд явах хүртэл 1-ээс 2 сар болно гэдэг чинь бас энэ чинь бас харамсалтай биз дээ. Тэнд чинь бизнес эргэлдэж байна, 5 төгрөг эргэлдэж байна. Хүмүүс маш яаралтай урагшаа юмаа гаргачих энэ боломж бололцоог бүрдүүлж өгөөч л гэж хүсэж байгаа юм зүгээр. Цааш цаашдаа энэн дээр та бүгд маань битгий цаг хугацаа алдаарай.

Хэрвээ дахиад ийшээ тийшээ шилжилт хөдөлгөөн хийвэл.

Б.Бейсен: Нарантуяа дарга.

А.Нарантуяа: Мал эмнэлгийн ерөнхий газар дээр яг бичигдэж эхлэх албан ёсны яг зөвшөөрөл бол сүүлд ер нь шийдэгдсэн. Ургамал хамгааллын газар уу, манайх уу гэж байгаад тэгээд кодексын дагуу манайх руу шилжсэн. Би яг өөрөө энэ компанийн хүнийг хүлээж аваад аль болох Бичигтийн боомт дээр байцаагч ажиллуулъя гээд яг ирсэн бичиг болгоныг нь дор дор нь шийдээд явсан. Тэгээд би бас өөрөө хэлж байсан. Хаврын цаг хуурайшилт болж байна аль болох хурдлахгүй бол гээд Хятад руу гарч байгаа компани нь гарчхаад буцаж орж ирж ачигддаг байсан учраас жаахан хугацаа алдчихлаа гээд өөрсдөө тийм ойлголттой байсан. Тэгээд жоохон ойл ойлголтыг буруу өгсөн байна аа.

Ерөнхийдөө манай Мал эмнэлгийн ерөнхий газар гаалиас ирэх асуудал 12 бол 2 сарын 15-наас эхэлсэн. 4 сарын 21-нд бичигдсэн.

Тэгэхдээ мал амьтан тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүний гэрчилгээ бол манай дээр бичигдсэн. Ургамлын асуудал бол бичигддэггүй байж байгаад сүүлд шийдэгдсэн асуудал.

Б.Бейсен: Мандхай гишүүн асуулт асууя.

М.Мандхай: Би нэг хэдэн асуулт ХААЯ-аас асууя гэж бодож байна.

Энэ отрын бүс нийт ХАА-н энд хуваарилагдаж байгаа зардал дээр отрын бүс байгуулах хамгаалах дээр арван нэгхэн сая төгрөг тавьжээ. Яагаад энэ дээр ингээд ийм асуудал үүсчхэв ээ. Бэлчээрийн даац хэтэрсэн хатуу үйлчлэлтэй хүнд нөхцөл байдал үүсээд байж байдаг. Одоо бүүр сүүлдээ нөгөө оторлосон малчид маань бүүр отрын бүсээсээ ч гарахгүй ингээд газрын маргааны асуудал үүсээд ингээд хүндэрсэн нөхцөл байдалтай байгаа.

Тэгэхээр энэ бүсийг хамгаалах дээр ерөнхийдөө 11 сая төгрөг тавьж байна. Энэ тэгээд хамгаалагдаж чадах уу гэдэг асуулт байна.

Хоёрдугаарт энэ ХАА-н салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих урамшуулал гэж байна. Энэ яг тусдаа яг ямар урамшуулал вэ? Тэрнээс биш одоо энэ төсөв дээр бол сүүний, улаан буудайн, ноосны, арьс шир гээд бүгдийнх нь урамшуулал, хүнсний ногооны урамшуулал хүртэл тусдаа ингээд байна. Тэгэхдээ энэ дээр нь ХАА-н салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих урамшуулал гэдэг нь яг ямар ялгаатай юм бэ? Энэ дээр нэлээн өндөр дүнтэй. 160 сая төгрөгийн энэ

чинь хэд юм бэ? Тийм 160 сая төгрөгийн урамшуулал тавьсан байна. Энэ яг ямар ялгаатай юм бэ гэдгийг асуумаар байна.

Дараагийнх нь асуулт болохоор гадаад тусламжийн хөрөнгөөр 2025 онд энэ цахим хоршоо төсөл, Цахим хоршоо төсөл ТХН гээд 2 төсөв тавьсан байна. Энэ яг ямар цахим хоршоо төсөл вэ? Энийг нэг тодруулъя аа.

Дээрээс нь гадаадын зээл. Энэ дээр МАА эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл гэж байна. 902 сая төгрөг бараг тэрбум орчим төгрөг байна. Энэ ямар төсөл юм бол? Энэ хүнсний ногоо тариалалт усалгаатай газар дэмжих төсөл гээд бас байна. Энэ бүүр 10.2. 10 тэрбум 200 бараг 300 орчим сая төгрөгийн өндөр өртөгтэй. Энэ одоо хэзээ дуусах хэзээ эхлээд энэ хэзээ дуусах гэж байгаа төсөл вэ гэдгийг тодруулж өгөөрэй. Дахиад ХАА, Хөдөөгийн хөгжил 2 гэсэн төсөл байгаад байна тийм ээ. Энэ тэгээд үнийн дүн нь болохоор 10 сая гэхэж байгаа юм. Энэ яг ямар төсөл юм. Тэгээд яг ямар ажил хийгдэх юм бэ гэдгийг тодруулж өгөөч.

Ургамал малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэмжээг сайжруулах төсөл гээд байгаа юм. Энэ хүнсний аюулгүй байдалтай холбоотой ингээд төслүүд үнийн дүнгүүд оруулаад тавьчихсан байгаад байгаа юм. Энэ яг хүнсний аюулгүй байдалтай холбоотой ямар ажлууд хийгдэх гэж байгаа вэ? Энэнээс нь тодруулаад өгөөрэй.

Мал эмнэлгийн ерөнхий газрын энэ төсөв хасагдсан байна.

Б.Бейсен: Мандхай гишүүн нэг минут.

М.Мандхай: Сангийн яамнаас асуугаад энэ хасагдсан байна. Энэ ямар үндэслэлээр хасагдсан юм бол гэдгийг тодруулаад өгөөрэй.

Хоёрдугаарт энэ ЖДҮ-лэлийг дэмжих дээр 44.8 сая төгрөг тавигдсан юм шиг байна. Тэгсэн мөртөө энэ эргэн төлөлт нь тэг гээд тавьчихсан байх юм. Тэгэхлээр энэ гаргаж байгаа мөнгө нь эргэн төлөлт байхгүй юм уу? Энэ 2025 онд эргэн төлөлт байхгүй гэж тавьж байгаа юм уу? Яг юу гэсэн үг юм бэ? Энийг бас тодруулъя. Энэ ер нь ашигтай ажиллаж байгаа юм уу үгүй юу? Зээлийн батлан даалтын сан дээр яагаад энэ 45 сая төгрөг тавьсан юм? 45 сая юм шиг байна тиймээ.

Уучлаарай тэрбумаа тийм байна. Тэгвэл 45 тэрбум төгрөг тавьснаа 5 тэрбумыг нь хасчихсан байгаад биш 40 тэрбумыг нь хасаад 5 тэрбум төгрөгийг нь үлдээчихсэн байна. Гэтэл шинэ хоршоо хөдөлгөөн чинь 5 жил хэрэгжинэ гээд ингээд зээлүүд.

Б.Бейсен: Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Ерөнхийдөө хэмнэлттэй төрийн байгууллага өөр дээрээ ав гэдэг л ийм л улс төрийн шийдэл гаргаад л тэгээд л хасаж болох, багасгаж болох л бүх л үзүүлэлтээр хасаж байгаа. Мэдээж нөлөөлөл сөрөг орно. Гэхдээ аль болох бид нар урсгал дотроо зохион байгуулаад тэгээд дотор нь эрэмбэлж байгаад л тэгээд л аль болохоор эрсдэл багатай байхаар л ингээд л зохицуулна даа. Ингээд танд тайлбарлавал бүхий л үзүүлэлт дээр манайх үндсэндээ ингээд хасалтууд явж байгаа. Тэр усалгааны төсөл бусад тэр төслүүдтэй холбоотой дэлгэрэнгүй мэдээллээ танд бичгээр хүргэе.

Жишээлбэл юу гэхэд ЖДҮ гэхэд тэр 40 гэдэг маань өөрийн орлогоороо л хийнэ. Улсын төсвөөс тэг байхгүй юу. Ерөөсөө байхгүй мөнгө тавигдаагүй. Тэгсэн мөртөө 40 тэрбумыг бүрдүүлээд энэ ЖДҮ-ийг дэмж гэдэг ийм Улсын Их Хурлын шийдвэртэй. Тэгээд тэрийгээ бид нар зохион байгуулаад явж байна. Эндээс ямар нэг хасагдах юм байхгүй. Зээлийн батлан даалтын сан буюу ахиад л нөгөө ЖДҮ-ийг дэмжихэд батлан даалт гаргах 45 тэрбумын эх үүсвэр байсан. Энийгээ 40 тэрбум нь үндсэндээ хураалгаж байна гэсэн үг. Тэгэхээрээ тэр хэмжээнд ЖДҮ-ийн зээлийг батлан даах, малчдын хоршоог батлан даах энэ үйл ажиллагаанд бас ахиад л тодорхой хэмжээнд нөлөөлнө өө л гэсэн үг. Отрын бүс дээр үндсэндээ энэ жил ялангуяа Увс, Ховд, Баян-Өлгий зуншлага сайнгүй байгаа. Тэнд нэлээн 5 сая гаруй малын асуудал үүснэ. Тэгэхээр бид энэ мал мах экспортыг нэлээн сайн анхаарах, энэ малын вакцинжуулахаар нэлээн сайн анхаарах. Тэгээд өвөлжилтөд бэлтгэх үүднээс энэ отрын бүс нутаг дахь хашаа саравч, худаг ус, тог, дэд бүтэц гээд анхаарах зайлшгүй шаардлагууд байгаад байдаг.

Мөн л бас тодорхой хэмжээнд хасагдаж байгаа. Гэхдээ отрын асуудал гайгүй ээ нэг нийтдээ нэг аймгийн дотрын бүс чинь нэг 928 сая төгрөгийн төсөвтэй байсан тэгээд 160 саяар хасагдаад 768 үлдэж байгаа. Энэ улсын хэмжээнд 20 гаруй хүний бүрэлдэхүүнтэй нэг ийм улсын хэмжээнд отор өвөлжилтийг зохион байгуулдаг манай нэг ийм нэгж байдаг. Тэгээд энэ хүрээндээ бид нар яамнаас бусад зардлаасаа жоохон дэмжлэг туслалцаа үзүүлээд тэгээд ард нь гарна л гэж бодож байна даа.

Гадаад зээл тусламж манай дээр нэг 2, 3 төсөл байгаа. Үндсэндээ ингээд хэрэгжээд дуусаж байгаа юм байна лээ. Зарим нь одоо энэ 6 сараар хаагдаж байгаа юм байна лээ. Зарим нь одоо энэ оны сүүлээр хаагдах юм байна лээ буюу үндсэндээ зарцуулалт нь гаргаад тайлан нь хийгдээд үр дүнгүүдээ түрүүчээсээ бид нар хийсэн юмнуудаа хүлээж аваад л яваад байгаа юм. Хүлэмжүүд байна, хөв цөөрмүүд байна, усалгааны системүүд байна, зооринууд байна гээд янз янзын юмнууд хүлээж аваад л гүйцэтгэл нь гараад л, хүлээж аваад л, гүйцэтгэл гаргаад л, тэр гүйцэтгэлээр нь Сангийн яам санхүүжүүлээд л явдаг. Тийм төслүүд дэлгэрэнгүй мэдээллийг танд өгье. Манайд 2 төсөл байгаа даа.

Б.Бейсен: Мандхай гишүүн тодруулах гээд байгаа юм уу тодруулъя.

М.Мандхай: Тодруулчихъя даа. Цахим хоршоо төсөл гээд нэг санхүүжилт байгаад байна. Энэ яг тусламжаар гэхихсэн байна. Энэ яг ямар учиртай төсөл юм болоо гэдгийг хэлээд өгөөрэй. Тэгээд энэ бусад миний асуусан төслүүдийг нэлээн тодорхой би хариулт авахгүй бол болохооргүй байна. Тэгээд Сангийн яам ер нь одоо энэ зээлийн батлан даалтын сангийн мөнгийг ийм их хэмжээгээр таначихлаа. 45 тэрбум төгрөгийн 40-ийг нь ингээд таначихсан юм байна. Тэгээд энэ хэрэгжээд явж байгаа олон төслүүд чинь зогсохоор харагдаж байна. Тэгэхээр энэ дээр ер нь яг ямар байр суурьтай ямар үндэслэлээр хасчхав гэдгийг би нэг тодорхой асуумаар байгаа юм. Ер нь энэ чинь ямар үнэлгээнд тавьсан юм. Ямар үндэслэлээр энэ төслүүдээ хассан юм бэ гэдэг дээр хариулт өгөөч.

Б.Бейсен: 3 номер, Ганбат дарга, Төрийн нарийн.

Ж.Ганбат: Төсвийн тодотгол гэж энэ зардал хасаж байгаа бол үндэс нь эдийн засгийн нөхцөл байдал бид гадаад орчны нөлөөллөөс болоод бас амаргүй байна.

Тэгээд энэ дээр эдийн засгийн дотоодын нийт бүтээгдэхүүнийг бид номинал тоогоороо 2025 онд 95 их наяд гэж тооцож байсан. Энэ бол 5 их наядаар буураад 90 их наяд болохоор байна. Эдийн засгийн өсөлтийг 8 хувь гэж тооцож байсан 5.5 болохоор байна гэдэг тэгээд нийт экспорт маань 3 тэрбум амдоллороор буурахаар ингээд нийт импорт ингээд бас 1.1 тэрбум доллороор ингээд буурч байгаа. Мөн гол нөгөө экспортын гол бүтээгдэхүүн болох нүүрсний үнэ 40 гаруй хувиар буурсан. Энэ цаашид бас буурч болзошгүй нөхцөл байдал үүсэж байгаа энэ нөхцөл байдлаас биднээс хамаарахгүйгээр бас гадаад хүчин зүйл олон улсын нөхцөл байдлаас хамаараад ингэж байгаатай холбогдуулаад төсвийн орлогыг бид 3.3 их наядаар бууруулж тооцсон.

Цаашид бас энэ нөхцөл байдал.

Б.Бейсен: Ганбат дарга гүйцээж хариулах юм уу? Цаашид нөхцөл байдал улам муудвал бид бас энэнээс цаашаа бүүр хатуу арга хэмжээнүүдийг авна. Тэгээд энэ нөхцөл байдлыг Засгийн газар дээр ярилцсаны үндсэн дээр төсвийн тодотголыг оруулж ирж байгаа. Тэгээд хэмнэж болох зардлуудыг бүгдийг нь бууруулж байгаа. Тэгээд ер нь төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулах энэ тэр гээд бас нэлээн хатуухан л төсөв оруулж ирж байгаа л даа. Энэ хүрээнд л яг зарчим баригдаад л бүх сайд нар дээрээс таналт зардлыг бууруулж байгаа. Тэгээд төсвийн тодотгол батлагдах юм бол төсвийн ерөнхийлөн захирагч нар урсгал зардлын дүн дотроо багтаагаад зардлаа эмхлэх байдлаар авч үзэх боломжтой. Хөрөнгө оруулалт урсгал хоёроо хоорондоо гүйж болдоггүй ийм хуулийн заалттай байгаа учраас энэ хүрээндээ л энийгээ авч үзнэ л гэж үзэж байгаа юм.

Б.Бейсен: Энэ төсвийн ерөнхийлөн захирагч нар батлагдсан төсвийг бас хуульдаа захираад үр ашигтай зарцуулах шаардлагатай байна. Сая Сангийн яамны төрийн нарийн маань хэллээ. Бас энэ хүндрэх хандлагатай ер нь төсөв хүнд төсвийн орлого нүүрсний экспорттой холбоотой буурч байгаа. Түрүүн сайдууд бас танилцууллаа.

Тийм учраас ер нь үр өгөөжтэй зарцуулаад цаашдаа ер нь жилийн эцсээр биш 6 сараар бас энэ төсвийн хэмнэлтийн асуудал яригдах байх.

Бас 2 асуудал асууя гэж бодож байна. Энэ вакцины төсвийг тавихгүй бол бас нэлээн хүндрэлтэй асуудал гарах вий. Энэ малын халдварт өвчин мал махны экспортоор нөлөөлж өгөх вий. Энэний тендерийн асуудал Нарантуяа дарга яг танайх зарласан юм уу, худалдан авалтын газар зарласан юм уу энэ юуг тэнд өгсөн юм уу? Тэгээд яг хэд нь шалгарсан юм. Энэ шалгаруулчхаад гэрээ нь яагаад хийгдэхгүй байгаа юм. Хэний буруугаас болсон юм 1 дүгээрт.

Хоёрдугаарт энэ өвөлжилтийн бэлтгэл ажил өвс тэжээлийн нөөц бэлтгэх ажил дээр төсөв тавьсан уу? Ганбат дарга аа? Яагаад гэвэл одоо энэ баруун аймгууд зуслан гарч чадахгүй одоогоос өвс тэжээл өгч эхэлж байна гэнэ малдаа. Нөгөө талаар энэ ЭМД-ын сангийн асуудал энд байсан өчигдөр Энхболд ЭМД-ын ерөнхий газрын дарга ЭМД-ын санд ямар ч мөнгө байхгүй 9.2 тэрбум төгрөгийн өртэй байна дампуурчихлаа гээд юм тавьчихсан байхад тэр үнэн үү худлаа юу? Нөгөө талаар нэг когийн төсөв байгаа. Энийг хассан нь буруу юм шиг байх юм. Бэлтгэл ажлаа хангах ёстой. Одоо 2026 онд чинь манайд чинь олон улсын юунууд бас ирэх ёстой энэ дээр. Энэ 4 дээр асуулт асууя.

Нарантуяа дарга эхлээд хариулчих. 4 номер.

А.Нарантуяа: Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг улсын төсвийн хөрөнгөөр манай Мал эмнэлгийн Ерөнхий газар зохион байгуулсан. Ингээд сайдын А17 тоот тушаалаар батлуулсан нийт 12 бүлэг, 14 багц тендерийн худалдан авах ажиллагааг 100 хувь зохион байгуулсан.

Тэгээд нийт гоц халдварт өвчинтэй тэмцэх, шүлхийн өвчин, бог малын мялзан өвчинтэй тэмцэх вакцин худалдан авах үйл ажиллагаа бол 5 сарын 23-нд сүүлийн нээлт хийгдэж сая 6 сарын 7-нд гэрээ байгуулагдахаар явж байтал гомдол гарсантай холбогдуулан өнөөдрийн байдлаар гол 2 вакцины худалдан авалтын ажиллагаа ингээд гомдол гарснаар саатуулагдсан байна аа. Тэгээд өнөөдөр 6 сарын 27-ны бичгийг өнөөдөр албан ёсоор хүлээж авсан. Дахиж Сангийн яамнаас дахиж үнэлгээ хийе гэсэн хариу бичиг ирсэн байна аа. Тэгээд бусад тендерүүд амжилттай явагдсан. Бог малын шүлхий өвчнийг болохоор энэ бол бас жаахан өөр үйл ажиллагаа явдаг. Яагаад гэхээр гоц халдварт өвчний 4 төрлийн вакциныг манай Монгол Улс импортоор гаднаас авдаг. Био үйлдвэрийн 17 нэр төрлийн вакцин, архаг халдварт өвчний вакциныг бол Монгол Улс өөрөө хангадаг. Үүн дотор нэг өвчний вакцин байгаа. Цэцэг өвчний вакцин. Бусад өвчнийг гадаадаас авдаг учраас сүүлийн 2 жил бид нар ийм бодлого тавьж байна. Яагаад гэхээр олон улсын тендер үйлдвэрлэгчээс нь шууд харьцаж явж байгаа.

Тийм учраас тэр вакцины хэвшил ялангуяа дэд хэвшилд тохирсон АО хэвшлийн ялангуяа шүлхий дээр Английн перпрэйт буюу референс лабораториор баталгаажсан омгийн вакцин. Бог малын мялзан өвчнийг бас мөн адилхан. Ингээд үйлдвэрлэгч орон нь дэлхийн жагсаалтад орсон Референс лабораториор баталгаажсан вакциныг авч байгаа учраас энэ худалдан авалтын хэмнэлтээс өнгөрсөн жил Монгол Улсын Мал Эмнэлгийн Ерөнхий газар 5 тэрбум төгрөгийн вакцины нөөцтэй байгаа тулдаа өнөөдөр гоц халдварт өвчингүй өнөөдрийн байдлаар ингээд тайван байна аа.

Тэгээд Сангийн яамнаас мал эмнэлэгт төсвөөр батлагдсан энэ тендерийн үйл ажиллагааг явуулахад дэмжлэг үзүүлж энэ тендерийн үйл ажиллагааг явна гэдэгт итгэлтэй байна. Яагаад гэхээр бид нар саяхан сая Ерөнхий сайдын мэдээлэлд орсон Дэлхийн мал амьтны эрэл эрүүл мэндийн байгууллагын дээд чуулганаар Монгол Улс шүлхий өвчинтэй тэмцэх хөтөлбөрөө батлуулсан. Энэ хөтөлбөрийг бид нар яг энэ стратегиараа 4 жил явах юм бол Монгол Улс вакцинтай эрүүл бүс болж манай Монгол Улсын мах 3 доллар биш 7-гоос 8 долларт хүрэх ялангуяа хамгаалалттай аж ахуй гэсэн хөтөлбөр, Засгийн газрын мөрийн хөтөлбөртөө явуулсан учраас энэ хөтөлбөр явж байгаа учраас энэ вакцины үйл ажиллагааг саатахгүй гэж найдаж байна аа.

Б.Бейсен: Ганбат дарга хариулъя. 3 номер.

Ж.Ганбат: Өвс тэжээл дээр яах вэ онцгой шадар сайдын багцад өвс тэжээлийн нөөц бэлдэх зардал гээд Онцгой байдал дээр улсын нөөцийн өвс гээд дүн байгаа юм байна. Энэ тэгэхдээ бас нөгөө нууцад орчихсон учраас хэлж болох юм уу болохгүй л юм шиг байна. Тэгэх дээр энэ дүнгээс яах вэ тодорхой хувь нь хэмнэлт орсон. Гэхдээ цаана нь бол 80, 90-ээд хувь нь үлдэж байгаа юм байна. Тэгэхдээ тэрэндээ зохицуулаад явах бололцоотой.

Нөгөө талдаа Засгийн газрын нөөц сангийн хөрөнгийг 50 тэрбумаар нэмэгдүүлж орж ирж байгаа. Тэгээд яах вэ энэ хүрээндээ нөгөө өвөлжилт байгалийн гэнэтийн гамшиг тохиолдсон зардлаа гаргаад явах бүрэн бололцоотой л доо.

Б.Бейсен: Копын төсөв тавигдаж байгаа гэсэн үү.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гараагүй байна.

Монгол Улсын 2025 онд Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 онд төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 онд төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн 2 дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Төсвийн тодотголын 2 дахь хэлэлцүүлэг хийсэн талаар Байгаль орчин, хүнс, хөдөө ахуйн байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулна аа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан дар хаасныг мэдэгдье.

Байнгын хорооны гишүүд, ажлын хэсэгт баярлалаа.

Хамтарсан хурал Их эзэн Чингис хаан танхимд болох юм байна. Ажлын хэсгийнхэн, гишүүд очоорой.

17.46 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА